

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

**НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин/ биелэлт	Үнэл-гээ
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.1.</b> Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг Дэлхийн геодезийн сүлжээний 2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.					
1.1.1	Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний зураглал	Төсвийн тооцоо-1	1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 эринд шилжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага, төсвийн тооцоог гаргаж, 2024 оны төсөвт тусгуулахаар Засаг даргад хүргүүлсэн байна.		
1.1.1.1	Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний зураглал хийх төсвийн тооцоо гаргах	Төсөв баталсан аймаг сумын тоогоор Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн сумын тоогоор	<b>Жилийн эцэст:</b> 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 эринд шилжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага, төсвийн тооцоог гаргаж, 2024 оны орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулсан байна.	Дархан-Уул аймгийн Хонгор сумын төвд 924 га, Зулзагын голд 1262 га, Дархан сумын 1, 2-р багийн үерийн далангаас эхлэн Хараа гол, төмөр зам 2-ийн хооронд Орхон аймагруу салдаг замын уулзвар хүртэлх 2859 га талбайд 1:1000 масштабтай зураглал хийлгэх төсвийг гарган, 2024 оны орон нутгийн төсөвт тусгуулах саналыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь: 80%	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2.</b> Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станцыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил зураглалын үйл ажиллагаанд ашиглана.					

1.2.2	GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын үйл ажиллагаа	1. Байнгын ажиллагаатай станц-43 2. Бодит агшны хяналтын хэмжилт - 4	43 Байнгын ажиллагаатай станцыг нэгдсэн сүлжээнд холбогдож, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд алдаагүй зөв хэмжилт хийх боломж бүрдсэн байна.		
1.2.2.1	GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах	Байнгын ажиллагаатай станц-2	GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тасралтгүй хэвийн ажиллагааг ханган ажилласан байна.	2023 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай станц тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Бага хэмжээний саатал доголдолыг цаг тухай бүрт газар дээр нь очиж арилгаж ажиллалаа. Хэрэгжилтийн хувь: 100%	
1.2.2.2	Аймгийн төвийн GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг бодит агшны хэмжилтээр хяналт тавих	Бодит агшны хяналтын хэмжилт - 4	Аймгийн төвийн станцын бодит агшны хэмжилтийн засвар дамжуулалтыг 2 удаагийн хэмжилтээр хяналт тавих, Хяналтын хэмжилтийн үр дүнг улирал тутамд ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Дархан–Уул аймгийн Дархан суманд байрлах GNSS-ийн байнгын ажиллагаатай станцад тулгуурлан Гравиметрийн 035, GPS-ийн сүлжээний 811, 5707, 012, 056 цэгүүд дээр бодит агшны RTK хэмжилт хийж гүйцэтгэн 192.168.20.24 /Geodesy/ GNSS Дархан хавтсанд байршууллаа. Бодит агшны хяналтын хэмжилтийг 4 улиралд хийсэн. Хэрэгжилтийн хувь: 100%	
1.2.2.3	GNSS-ийн хэмжилт хийх, өгөгдлийг ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	Аймгийн төвд байрлах GNSS-ийн сүлжээний цэг дээр 12 цагийн статик хэмжилт хийх	<b>Эхний хагас жилд:</b> ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжих боломж бүрдсэн байна.	2023 оны 05 сарын 31-ны өглөөний 08 цагаас оройн 20 цаг хүртэл геодезийн байнгын цэг тэмдэгт 811 дээр 12 цагийн статик хэмжилт хийсэн. Хэрэгжилтийн хувь: 100%	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.7.</b>					
<b>Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.</b>					
1.7.1	Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх	Мониторингийн 350 цэг	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний 1100 цэгээс мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, бусад байгууллагууд ашиглах нөхцөл боломжоор хангагдсан байна.		

1.7.1.1	21 аймгийн Хот, тосгон бусад суурины газрын мониторингийн цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	Байнгын ажиглалтын мониторингийн цэгийн тоо	<p><b>Эхний хагас жилд:</b> Батлагдсан удирдамжийн дагуу аймгийн ГХБХБГ Хот, тосгон, бусад суурины газрын мониторингийн цэгт хээрийн судалгааны ажлыг зохион байгуулан ажилласан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Аймгийн хот, тосгон бусад суурины газрын мониторингийн цэгт хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж, хөрсний эрүүл ахуй, хүнд металлын бохирдлын судалгааны ажлын үр дүн, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	Хот тосгон бусад суурины газрын мониторингийн цэгт газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд мониторингийн цэгийн судалгааг гарган, шинээр судалгаа хийх шаардлагатай мониторингийн 10 цэгийн байршлыг тодорхойлон 2023 оны 11-р сарын 17-ны өдөр бичмэл тайланг ГЗБГЗЗГ-газарт хүргүүлсэн Хэрэгжилтийн хувь: 100%
1.7.1.2	Ойн сан бүхий газар, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын судалгааг гаргаж, мониторингийн цэгийг өтгөрүүлэх талаар суурь мэдээлэл бүрдүүлэх	Суурь мэдээллийн *.shp файл, атрибут мэдээлэл	<p><b>Жилийн эцэст:</b> Аймгийн хэмжээнд ойн сан бүхий газар, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын судалгааг гаргаж, мониторингийн цэгүүдтэй давхцуулан, цаашид мониторингийн цэгийг өтгөрүүлэх байршлын талаар санал боловсруулсан байна.</p>	Аймгийн хэмжээнд ойн сан бүхий газарт мониторингийн нэг цэг байдаг, усны сан бүхий газарт ямар нэгэн мониторингийн цэг байхгүй байна. иймд шинээр мониторингийн цэг байгуулах судалгааг хийхэд усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд Дархан суманд 1399, Орхон 38, Хонгор 94, Шарын гол 151 нэгж талбарын судалгааг гаргаж мониторингийн цэгүүдтэй давхцуулан, цаашид мониторингийн цэгийг өтгөрүүлэх байршлын талаар санал боловсруулан 2023 оны 12 сарын 15-ны өдрийн 777 дугаар албан тоотоор ГЗБГЗЗГ-т хүргүүлээд байна. Хэрэгжилтийн хувь: 100%
1.7.1.3	Хог хаягдлын төвлөрсөн цэгийг шинээр байгуулах, шаардлага хангахгүй төвлөрсөн цэгийг нүүлгэх талаарх саналыг аймгийн хэмжээнд боловсруулах	Шинээр байгуулах шаардлагатай хог хаягдлын төвлөрсөн цэг, нүүлгэх шаардлагатай хогийн цэгийн судалгаа	<p><b>Эхний хагас жилд:</b> Аймгийн хэмжээнд хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршлын мэдээллийг гаргаж, хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн төвлөрсөн хогийн цэгийн мэдээлэлтэй тулгаж дүн шинжилгээ хийж, шинээр байгуулах шаардлагатай газрын судалгааг гарган ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b></p>	Дархан-Уул аймгийн хог хаягдлын төвлөрсөн цэг болон шинээр байгуулах шаардлагатай хогийн цэгийн судалгааг гарган 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 374 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь:100%

			Шаардлага хангахгүй төвлөрсөн хогийн цэг, шинээр байгуулах шаардлагатай хогийн цэгийн судалгааг гаргаж, ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	
1.7.1.4	Хот суурин газрын хаягдлын аж ахуйн энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршилд холбогдох хууль тогтоомж, дүрэм, зааварт зааснаар үнэлгээ өгч тодотгох, баталгаажуулах ажлыг зохион байгуулж хог дарж булсан хэсэг, түүний орчимд ногоон төгөл үүсгэх, тохижуулах ажлыг зохион байгуулах	- Хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэгдсэн цэгийн тоо  - Ногоон төгөл үүсгэсэн талбайн хэмжээ	Хот байгуулалтын норм ба дүрэм, холбогдох журам, стандартад нийцсэн байршилд Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршлыг тодорхойлсон байна.  Хог хаягдлын цэгт ногоон төгөл үүсэж нөхөн сэргээлт хийгдсэн байна.	Дархан-Уул аймгийн Дархан суманд 6-р баг 171 га төвлөрсөн хог хаягдлын цэг, Хонгор сум 30 га энгийн хог хаягдалын цэг, Хонгор сум 17,1 га Дархан төмөрлөгийн энгийн хог хаягдалын цэг, Орхон сум 22 га энгийн хог хаягдлын цэг тус тус цахим системд бүртгэгдсэн. Дархан сумын хог хаягдлын цэгийн 15 га газрын хог дарж булшилсан байна. Бараат хогийн цэгийг тойруулан ногоон хөшиг татахаар 47 га газрыг төлөвлөн хашаажуулаад байна. Хэрэгжилтийн хувь: 100%
1.7.1.5	Сансрын зураг болон хиймэл дагуулын мэдээлэл ашиглан газрын бүрхэвчийн өөрчлөлтийг тодорхойлж, зураглалыг гарган, газар дээр нь таарцыг шалгаж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	Судалгаа - 1	“Sentinel-2” болон бусад хиймэл дагуулын мэдээг “Mongolian data cube”-ээс татаж авч дүн шинжилгээ хийсэн байна. Газар ашиглалт, газрын бүрхэвч, ургамлын зургийг 06-10 дугаар саруудад сар бүрээр гаргаж, ажлын үр дүнг орон нутгийн удирдлагууд, холбогдох хурлуудад танилцуулж, ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Landsat-8 OLI/TIRS хиймэл дагуулын мэдээнээс 2022 оны 6 сарын 15, 8 сарын 18, 10 сарын 15-ны 11 сувгийн мэдээ бүхий 2 планшэйтийн Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийг багтаасан растер мэдээг татаж авсан, 2023 оны мөн саруудын мэдээг татаж ургамалжилтын индекс болох NDVI-г бодуулсан, (Mongolian data cube-ээс аймгийн хэмжээний дата татаж 2023 2022 оны ургамалжилтын харьцуулсан зураг хийж тайлан дүгнэлтийг ГЗБГЗЗГ Газар Суурь судалгаа мониторингийн хэлтэст хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь: 100%
1.7.1.6	Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын аргыг ашиглан бэлчээрийн	Аймгийн хэмжээнд бэлчээрийн ургац, даацын зураг, тоон мэдээ – 1	<b>Эхний хагас жилд:</b> Зайнаас тандан судлалын аргаар 2022 оны мэдээнд үндэслэн аймгийн хэмжээнд бэлчээрийн	Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын аргыг ашиглан 2023 оны 6 сарын 15, 8 сарын 18, 10 сарын 15-ны 11 сувгийн мэдээ бүхий 2 планшэйтийг аймгийн хэмжээнд боловсруулж бэлчээрийн газрын биомассыг тооцох, бэлчээрийн даацыг тодорхойлж, дүн

	<p>газрын ургац, даацыг тодорхойлох, үр дүнг орон нутгийн удирдлагууд, холбогдох хурлуудад танилцуулах хэрэглэгчдийг мэдээллээр хангах</p>		<p>газрын биомассыг тооцох, бэлчээрийн даацыг тодорхойлж, дүн шинжилгээ хийгдсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Зайнаас тандан судлалын аргаар 2023 оны мэдээнд үндэслэн аймгийн хэмжээнд бэлчээрийн газрын биомассыг тооцох, бэлчээрийн даацыг тодорхойлж, 2022 он, 2023 оны үр дүнг харьцуулан дүн шинжилгээ хийсэн байна. Ажлын үр дүнг орон нутгийн удирдлагууд, холбогдох хурлуудад танилцуулах хэрэглэгчдийг мэдээллээр хангасан байна. Зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар тайлан гаргаж, ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>шинжилгээг хийж тайланг байгууллага болон орон нутгийн мэдээллийн сайтууд, ХХААГ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь: 100%</p>
1.7.1.7	<p>Улсын тусгай хэрэгцээний газрын мониторингийн цэгийг шалгах</p>	<p>Судалгаа – 1, шинээр мониторингийн цэг байгуулах шаардлагатай газрууд</p>	<p><b>Эхний хагас жилд:</b> Аймгийн хэмжээнд тусгай хэрэгцээний газруудад мониторингийн цэгийг ажиглалтын талбаруудыг бүрэн төлөөлж буй эсэхийг судлах, огт мониторингийн цэг байгуулагдаагүй тусгай хэрэгцээний газруудын судалгаа гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Аймгийн тусгай хэрэгцээний газруудад нэмж байгуулах шаардлагатай мониторингийн цэгийг тодорхойлж, шинээр байгуулах газруудын байршлыг сонгож тоон мэдээллийн санг үүсгэж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>Улсын тусгай хэрэгцээний газрын мониторингийн цэг 59 байдагаас манай аймагт байхгүй болно. шинээр байгуулах мониторингийн цэгийн судалгааг хийж байна, Тоон мэдээллийг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь: 100%</p>

1.7.2	Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо	Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.		
1.7.2.1	УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээ”-ний хүрээнд тариалангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг зохион байгуулах	Тариалангийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, баталгаажсан тайлан дүгнэлтийн тоо	<p><b>Эхний хагас жилд:</b> Газрын кадастрын мэдээллийн сангаас тариалангийн газрын нэгж талбарын мэдээллийг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж, тариалангийн захиалгат хянан баталгаа хийлгээгүй аж ахуй нэгж байгууллага, иргэдэд мэдэгдэл хүргүүлж, захиалгат хянан баталгаанд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах. Тариалангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгаанд хамрагдсан эсэх судалгааг аймгийн хэмжээнд гаргаж, ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Аймгийн хэмжээнд тариалангийн газрын зориулалтаар олгогдсон газруудыг газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажилд бүрэн хамруулсан байна. Тариалангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>Тариалангийн зориулалтаар иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын дэлгэрэнгүй судалгааг тариалан бүхий сум бүрээр гарган аймгийн хэмжээнд нэгтгэсэн.</p> <p>Үүнээс газрын захиалгат хянан баталгаа хийлгэх шаардлагатай 1043 иргэн, аж ахуй нэгжийн дэлгэрэнгүй судалгааг гарган ГЗБГЗЗГ-газарт 2023.03.07-ны өдрийн 147 тоот албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн.</p> <p>Тусгай зөвшөөрөлтэй компаниудаар 7 нэгж талбар өөрсдийн хөрөнгөөр захиалгат хянан баталгаа хийлгүүлсэн байна.</p> <p>2018 онд Геобатоник ХХК аймгийн тариалангийн газрын хянан баталгааг хийж гүйцэтгэсэн. 2023 онд тариалангийн зориулалтаар газар олгогдоогүй байна. Учир нь атар газрыг тариаланд шилжүүлэх Засгийн газрын тогтоол гараагүй байгаа. Иймд шинээр газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийгдээгүй. шинээр шилжүүлэх талбайн хөрсний шинжилгээ хийгдсэн болно.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 100%</p>	

1.7.2.2	УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээ”-ний хүрээнд тариалангийн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулах, атаршсан газрыг эргэлтэд оруулах, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан байршил, арга хэмжээний тоо	<p><b>Эхний хагас жилд:</b> Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх шаардлагатай байршлыг тодорхойлж зураглан, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, эдийг засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Атаршсан газрыг эргэлтэд оруулсан, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлсэн арга хэмжээний биелэлт, зохион байгуулсан ажлын үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хавсралтын 3.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Дархан-Уул аймгийн Орхон сумын ИТХ-н 2022 оны 18 тоот тогтоолоор 1153,1 га, Хонгор сумын ИТХ-н 2022 оны 23 тоот тогтоолоор 2950,68 га газрыг тус тус атар газраас тариалангийн ангилал руу шилжүүлэх саналыг агентлагт хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын тогтоол шийдвэр гарахыг хүлээж байна. Хэрэгжилтийн хувь: 100%	
1.7.2.3	Бэлчээрийн газрын хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах.	Нөхөн сэргээлт, хамгаалах арга хэмжээ хийсэн арга хэмжээний тоо	<p><b>Жилийн эцэст:</b></p> <p>Бэлчээрийн газрын хөрсийг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, тайлан холбогдох мэдээллийн хамт ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	2022 оны бэлчээрийн газрын фото мониторингийн үр дүнд үндэслэн Орхон суманд доройтсон 13 га газрыг бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хашаалсан, 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 4 болон 5 дугаар зэрэглэлийн доройтсон бэлчээрийг хамгаалах нөхөн сэргээх ажлыг тусгуулахаар сумдын Засаг дарга нарт хүргүүлээд байна. Хэрэгжилтийн хувь:100%	
<p><b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8.</b> Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.</p>					
1.8.1	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах				

1.8.1.1	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	Хэрэгжилтийн тайлан-1	<b>Жилийн эцэст:</b> Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийг 1-р улиралд багтаан гаргаж, ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу 2019-2025 он хүртлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөнд Дархан-Уул аймагтай холбоотой 21 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс: 2023 оны байдлаар 9 арга хэмжээ тодорхой хэмжээний ажил, хөрөнгө мөнгө зарцуулагдан 50-80%-тай хэрэгжиж байна. Хугацаа дууссан 1 арга хэмжээ байна. 11 арга хэмжээ нь 2025 он хүртэл үе шаттайгаар хэрэгжинэ. 2023 оны хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлнэ. Хэрэгжилтийн хувь: 100%
<b>1.8.2</b>	<b>Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах</b>			
1.8.2.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	ГЗБЕТ-ний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-1	<b>Эхний хагас жилд:</b> Аймгийн ГЗБЕТ-ний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.  <b>Жилийн эцэст:</b> Аймгийн ГЗБЕТ-ний холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2016 онд батлагдсан. Үүний дараа 2018 онд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан тул аймгийн ГЗБ-ын төлөвлөгөөг тодотгох шаардлага үүссэн. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө тодотгох 450 сая төгрөгийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлийн 2023 оны 11 сарын 24-ны өдрийн 54 тоот тогтоолоор 2024 оны орон нутгийн төсөвт суулгасан. Хэрэгжилтийн хувь: 100%
<b>1.8.3</b>	<b>Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих</b>	<b>8 аймгийн болон нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө</b>	<b>Шинэчлэн боловсруулсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг холбогдох аймгуудад хүргүүлсэн байна</b>	
1.8.3.1	Аймгийн газар зохион Байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргах, түүнтэй холбоотой мэдээ судалгаагаар	Хэрэгжсэн арга ХЭМЖЭЭНИЙ ТОО	Эхний хагас жилд: Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэж, 2023 оны 01-р сарын 30-ны дотор Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна.	2022 оны Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 1-р сард ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой 2023 оны



	ГЗБГЗЗГ-ыг хангах			судалгаа, мэдээг ГЗБГЗЗГ-т 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. Хэрэгжилтийн хувь: 100%
1.8.4	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	16 сум	Жил бүр 18 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.	
1.8.4.1	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Хэрэгжсэн арга хэмжээний тоо	Жилийн эцэст: 4 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг цахим системд байршуулж, аймгийн хэмжээнд нэгтгэн 2023 оны 01-р сарын 30-ны дотор Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна.	Дархан-Уул аймгийн Орхон суманд 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 15 сая төгрөгөөр Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдэж Сумын ИТХ-ын 2019 оны 12 сарын 09-ны өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан. Үүнээс 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 3 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийн тайланг 2023 оны 1-р сард ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Орхон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг цахимд байршуулах эрхийг Вектор мэдээ ХХК-н дээр нээлгэсэн. - 2023 оны хэрэгжилтээр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу Орхон суманд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор газрын зориулалтаар /фермер/ 12.25 га газрыг төвлөсөн бөгөөд 2023.11.16-нд дуудлага худалдаа зохион байгуулагдаж 3 нэгж талбарт 3 иргэн оролцож ялагч тодроогүй. 7 нэгж талбарт санал ирээгүй учир дуудлага худалдаа хүчингүй болсон. Хонгор суманд 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 185 сая төгрөгөөр Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Сум нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө, байр зүйн зураглал зэрэг ажлууд хийгдэхээр Сумын ИТХ-ын 2022 оны 12 сарын 09-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан. Дээрх ажлуудыг хийхээр Тэгш хэм ХХК шалгарч гэрээ байгуулсан боловч ажлын хэмжээ их мөнгөн дүн бага шалтгаанаар гэрээгээ цуцалж дээрх төлөвлөсөн ажил хийгдээгүй болно. Хэрэгжилтийн хувь: 85%
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.9.</b> <b>Мэдлэгт суурилсан, иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгоно.</b>				

1.9.1	Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, байгалийн нөхцөл, нөөцийн чадавхид нийцүүлэн оновчтой зохион байгуулах, хуваарилах	Аймаг бүрээр боловсруулсан санал	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг боловсронгуй болгох саналыг боловсруулж, БХБЯ-нд хүргүүлсэн байна.		
1.9.1.1	Орон нутагт үүссэн хилийн цэсийн маргааныг шийдвэрлэхтэй холбогдох тооцоо, судалгаа, саналыг хүргүүлэх, иргэд олон нийтийг мэдээ, мэдээллээр хангаж маргааныг бууруулах, хилийн цэсийн маргааны судалгааг гарган ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	Аймаг бүрээр боловсруулсан санал	<p><b>Эхний хагас жилд:</b> Хилийн цэсийн маргааныг бууруулах ажлын хүрүүнд иргэд олон нийтийг мэдээ мэдээллээр хангаж ажилласан байдал, өмнөх онд бүртгэгдсэн хилийн цэсийн маргааныг шийдвэрлэсэн тухай тайлан мэдээ, саналыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Хилийн цэсийн маргааныг ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны А/209 тушаалаар батлагдсан зааврын дагуу бүртгэн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлсэн байна.</p>	<p>Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Дархан-Уул аймгийн Хонгор сумын хилийн цэс болох “Хонгорын даваа” цэг нь байрлалын хувьд маргаантай байгаа тул холбогдох материалуудыг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны цахим хурлаар танилцуулж саналыг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.</p> <p>2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Газрын харилцаа геодези зураг зүйн газраас томилогдсон ажлын хэсэг “Хонгорын даваа” гэх газрын маргаантай газар дээр ажиллаж тухайн үеийн зурган мэдээлэл, холбогдох материал болон тогтоол шийдвэрүүд, талбайн координат зэргийг танилцуулж санал солилцсон.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт 2023.11.20 өдрийн 712 тоот албан бичгээр Хонгор сумын хилийн цэсийн маргаантай холбоотой баримт материал, холбогдох судалгааг хүргүүлсэн.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 100%</p>	
1.9.1.2	Багийн нэр болон хилийн заагийг нарийвчлан шалгаж, засварлах	Баг бүрээр боловсруулсан санал	<p><b>Жилийн эцэст:</b> 2023 оны 03 дугаар сарын 15-ны дотор багийн нэр болон хилийн заагийг нарийвчлан шалгаж, ИТХ-ын тогтоол, тоон /*shp/ болон зурган мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 1995 оны 06 сарын 30-ны 18 дугаар тогтоолоор баталсан Шарын гол сумын Хайрхан /1-р баг/-ийн хилийн цэс нь Ландменежер программд алдаатай зурагдсан байгааг залруулж багуудын хилийн цэсийг зөв болгон зураглаж мэдээллийн санд оруулж өгөх тухай албан бичгийг 2023 оны 01 сарын 03 нд ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 100%</p>	

1.9.3	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд суурилсан Газар, байгаль, нийгэм, эдийн засгийн нөхцөл, нөөцийн мэдээлэлд үндэслэсэн орон зайн шийдлийг дэмжих нэгдсэн систем байгуулах	1 систем	Нэгдсэн системийг байгуулж, үйл ажиллагаанд оруулсан байна.	
1.9.3.1	Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд хууль тогтоомжийн дагуу тогтоосон хамгаалалтын бүс, зурвас газрын мэдээллийн санг хөтлөх	Төсөлд оруулсан хамгаалалт бүс, зурвас газрын нэгж талбарын тоо	<p><b>Эхний хагас жилд:</b> Шинээр буй болсон зам, шугам сүлжээний хамгаалалтын бүсийг системд оруулсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Шинээр буй болсон зам, шугам сүлжээний хамгаалалтын бүсийг системд оруулсан байна.</p>	Дархан-Уул аймгийн Дархан сум, Шарын гол сум, Хонгор сумын инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас газрыг мэдээллийн санд оруулах ажил 2021, 2022 онуудад хийгдсэн. Орхон сумын инженерийн шугам сүлжээний байр зүйн зураггүй тул хийгдээгүй байна. 2023 онд аймгийн хэмжээнд “Жэмнет” ХХК, “Мобинет” ХХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “МХС” ТӨХХК зэрэг олон улсын шилэн кабель болон, хот хоорондын шилэн кабелийн хамгаалалтын зурвасыг мэдээллийн санд оруулсан. Хэрэгжилтийн хувь: 100%
1.9.3.2	Сумын газрын даамлуудад Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн танхимын сургалт зохион байгуулах	Танхимын 1, Цахимаар -1 сургалт	<p><b>Эхний хагас жилд:</b> Шинэ томилогдсон болон бусад холбогдох даамлуудад цахимаар тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг ГЗБГЗЗГ-тай хамтран зохион байгуулсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн сургалтыг зохион байгуулж, сумдын бүх даамлуудыг чадавхижуулсан байна.</p>	2023.03.22, 2023.11.15-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын газрын даамлуудад газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем, газрын кадастрын систем, газрын мониторингийн системийн нийт 4 чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч танхимийн сургалт зохион байгууллаа. Мэргэжил арга зүйн зөвлөгөө видео зааварчилгааг тухай бүрт өгч мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Хэрэгжилтийн хувь: 100%

Стратеги төлөвлөгөөний зорилго 1.14.

Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих

1.14.2	Салбарын үйл ажиллагаанд цахим гарын үсэг болон тоон гарын үсэг нэвтрүүлэх	85 тоон гарын үсэг	Газрын харилцааны салбарын нийт албан хаагчид тоон гарын үсэг ашигладаг болсон байна.		
1.14.2.1	Тоон гарын үсгийн олголт хийх, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах боломжийг нэвтрүүлэх	- Тоон гарын үсэг эзэмшигчийн тоо - Тоон гарын үсгийг ашиглаж буй үйл ажиллагааны тоо	Тоон гарын үсгийн олголт хийсэн байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна.	Тоон гарын үсгийн токен төхөөрөмж 10 албан хаагчид олголт хийгдсэн. Байгууллагын тоон гарын үсгийн төхөөрөмж олгогдсон. Тоон гарын үсгийн төхөөрөмжийг Able, Egazar, E-Mongolia, Нийгмийн даатгалын цахим системд ашиглаж байна. Хэрэгжилтийн хувь: 100%	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.15.</b>					
<b>Төрийн архивын стандарт орчныг сайжруулах</b>					
1.15.1	Төрийн архивыг цахимжуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх	1764 хадгаламжийн нэгж	1764 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбоно.		
1.15.1.1	Архивын баримтыг цахимжуулах, цахим мэдээллийн сан үүсгэх	0 хадгаламжийн нэгж цахимжуулна.	<b>Эхний хагас жилд:</b> 20 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗГ-ын Архив, мэдээллийн төвтэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна. <b>Жилийн эцэст:</b> 40 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗГ-ын АМТ-тэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна.	12 сарын 11-ний өдрийн байдлаар архивын <a href="mailto:archive2@gazar.gov.mn">archive2@gazar.gov.mn</a> цахим системд 300 орчим хадгаламжийн нэгжийг бүртгэсэн байна. Байгууллагын үйл ажиллагааны 35 хадгаламжийн нэгжийг скайнердан цахимжуулсан. Хэрэгжилтийн хувь: 80%	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.16.</b>					
<b>Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах</b>					
1.16.1	Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, хяналт тавих	Зохион байгуулсан ажлын тоо	Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах талаарх ажлуудыг зохион байгуулсан байна.		

1.16.1.1	Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах, хяналт тавих, Нууц албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх	1 мэдээ	Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, нууц баримттай танилцах иргэний итгэмжлэлийг шинэчлэх, нууцын баталгаа авах, нотлох лавлагаа гаргаж өгөх, гадаад улсад зорчих эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний урьдчилсан мэдүүлгийг авах, шилжилт хөдөлгөөний мэдээллийг тус тус бүртгэлжүүлж, мэдээ тайланг ТЕГ-ын орон нутгийн тагнуулын газар болон ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2023 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээг 2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЕГ-ын орон нутгийн тагнуулын салбар болон ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	2023 оны 07 дугаар сарын 15-нд байгууллагын нууц хариуцсан мэргэжилтэн өндөр насны тэтгэвэрт гарсан. Өнөөдрийн байдлаар нууц хариуцсан мэргэжилтэн томилогдоогүй байна. Хэрэгжилтийн хувь: 100%	
1.16.1.2	Төрийн болон албаны нууцын тооллого хийх, дүн мэдээг хугацаанд нь явуулах	1 тооллого	<b>Жилийн эцэст:</b> Аймгийн ГХБХБГ-ын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын үзлэг тооллого хийсэн байна. Тооллогын мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Аймгийн Тагнуулын хэлтсээс ГХБХБГ-ын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын үзлэг тооллого хийсэн. Хэрэгжилтийн хувь: 100%	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.23. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.</b>					
1.23.2	Инженерийн дэд бүтэцтэй холбоотой мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх	Инженерийн дэд бүтцийн мэдээлэл	Төлөвлөлтийн инженерийн дэд бүтэц, бэлтгэл ажлын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн байна.		

1.23.2. 1	Инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний орон зайн тоон зургийг холбогдох хангагч, ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран баяжилт хийх, мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулах	Төлөвлөлтийн 7 давхаргын мэдээлэл	Аймгийн хэмжээнд Хот байгуулалтын кадастрын системд төлөвлөлтийн 7 давхаргын мэдээллийг бүртгэсэн байна.	Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт 44 гүйцэтгэлийн зургийг хүлээн авч инженерийн байгууллагатай хамтран Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. Үүнд: Барилга, байгууламж - 16, Үерийн далан суваг – 3, Гэрэлтүүлэг – 8, Цахилгааны өндөр хүчдэлийн шугам – 3, Авто зам – 9, Шилэн кабель – 2, Мэдээлэл холбооны антен – 3 Хэрэгжилтийн хувь: 100%	
1.23.3	<b>Хот байгуулалтын кадастрын мэдээллийн танилцуулах, сурталчилах санг</b>	<b>2 арга хэмжээг авч хэрэгжүүлэх</b>	<b>Хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг сурталчилсан байна.</b>		
1.23.3. 1	Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчилах	4 арга хэмжээ	<b>Эхний хагас жилд:</b> Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна.	Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг дараах байдлаар сурталчилж ажилласан. Үүнд: - 2023.03.17-ны өдөр Дархан-Уул аймгийн “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2023” зохион байгуулах үеэр 150 гаруй иргэнд - 2023.04.08-ны “Дархан барилга экспо-2023” үеэр 1300 орчим иргэнд - 2023.04.28-ны өдөр “Аюулгүй ажлын байр-бидний суурь эрх” сэдэвт сургалтын үеэр 85 инженер техникийн ажилчдад 2023 онд барилгын зураг төслийн архитектур төлөвлөлтийн даалгавар 83 боловсруулан батлуулж Хот төлөвлөлтийн онцгой нөхцөлд дулаан алдагдалгүй ногоон барилгын технологийг хэрэгжүүлэх талаар тусгаж ажилласан. Хэрэгжилтийн хувь: 100%	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.24.</b> <b>Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.</b>					

1.24.1	Аймгийн газар эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх	Хэрэгжилтийн хувь	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын төлөв байдал, чанарын хянан магадлагааны хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.		
1.24.1.1	Объектын эрсдэлийг үнэлэх, эрсдлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын тоо, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо	Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулсан байна. Торгууль, нөхөн төлбөрийг бүрэн барагдуулсан байна.	Тайлангийн хугацаанд төлөвлөгөөнд тусгагдсан 15 ААН-ээс 13 ААН-ийн барилгын материалын үйлдвэр, барилгын угсралтын үйл ажиллагаа явуулж байгаа объектод төлөвлгөөт хяналт шалгалтыг хийлээ. Хэрлэн зураглал ХХК, Өсөх урам ХХК-иуд санхүүжилтээс шалтгаалж үйл ажиллагааг зогсоосон. Шалгалтад хамрагдсан 13 ААН-ыг 02.1.2, 02.2.1 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 2 дунд, 11 нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтаар нийт 95 зөрчил, илрүүлж, шалгалтын явцад 67 буюу зөрчлийн 70.5%-ийг арилгуулсан. Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2 ААН-д хугацаатай үүрэг даалгавар бүхий албан шаардлага хүргүүлсэн. Шалгалтаар Барилгын тухай хуулийн хэрэгжилт 78.6% хангагдаж байна. Хэрэгжилтийн хувь: 100%	
1.24.1.2	Аймгийн ГХБХБГ-ын газар олголтын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчлийн тоо	Урьдчилан сэргийлэх шалгалтаар илрүүлсэн зөрчлийг бүрэн арилгуулсан байна.	Өмчилсөн газраасаа илүү гаргаж зөвшөөрөлгүй хашаагаа сунгасан нийт 28 иргэний зөрчил илрүүлснээс 19 иргэний хашааг татуулж зөрчлийг арилгуулан үлдсэн 9 нэгж талбарт цэг тогтоосон акт тавиулж хугацаатай шаардах хуудас хүргүүлэн арга хэмжээ авч ажилласан. Хэрэгжилтийн хувь: 100%	
1.24.1.3	Газрын нэгдмэл сангийн тооллогоор илэрсэн зөрчлийн арилгах, хяналт шалгалт хийх	Зөрчлийн тоо	2023 онд хяналт шалгалтад хамрагдсан объектуудад илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулсан байна.	Газрын нэгдмэл сангийн ангиллаас өөр зориулалтаар газрыг ашигласан байдалд хяналт шалгалт хийхэд Орхон сумын нутаг дэвсгэрт атар газар хагалсан зөрчил илэрсэн. Атар газар хагалсан иргэнд зөрчлийн хэрэг үүсгэн торгуулийн арга хэмжээ авч илүү ашигласан газрыг чөлөөлүүлэн зөрчлийг бүрэн арилгуулан ажиллалаа. Хэрэгжилтийн хувь: 100%	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.25.</b> <b>Хүн амын нутагшилт, суурьшлийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.</b>					

1.25.1	<p>Газрын ерөнхий хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэд олон нийтийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулах</p>	3 хэлэлцүүлэг	Улсын хэмжээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.		
1.25.1.1	<p>Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллага, иргэд олон нийтийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулах</p>	<p>1. Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 2. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 3. Кадастрын тухай хуулийн төсөл</p>	<p>Хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллага, иргэд олон нийтийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.</p>	<p>2023.02.16-нд Монгол Улсын Их Хурал, Барилга хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Дархан-Уул аймгийн ЗДТГ, Дархан, Сэлэнгэ аймгийн ГХБХБГ хамтран Газрын багц хуулийн төсөл болон Геодези, зураг зүйн тухай, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулах нээлттэй хэлэлцүүлгийг Дархан-Уул аймагт зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл 487 хүн оролцсон байна. Мөн Сэлэнгэ аймгийн төлөөлөл 50 хүн ирж оролцон санал өгсөн.</p>	



		4. Газрын төлбөрийн тухай хуулийн төсөл 5. Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл 6. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 7. Хот байгуулалтын хуулийн төсөл		Хуулийн төслүүдэд нийт 52 хүн санал өгсөн. Үүнээс Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 9 хүн, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 6 хүн, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 1 хүн, Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 35 хүн санал тус тус өгсөн байна. Энэхүү хэлэлцүүлэгийн талаар орон нутгийн 3 телевиз, 5 сайтаар иргэдэд мэдээ мэдээлэл хүргэж ажиллалаа. Хэрэгжилтийн хувь: 100%	
1.25.2	<b>Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох</b>	<b>Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт</b>	<b>Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.</b>		
1.25.2.1	Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх	Санал өгсөн төслийн тоо	Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгсөн байна.	-Монгол улсын үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл - Газар ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын төсөл - Зайнаас тандан судлалын аргаар тариалангийн газрын мониторинг хийх аргачилсан зааврын төсөл -Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах арга зүйн төсөлд тус тус санал хүргүүлээд байна. Хэрэгжилтийн хувь: 100%	
1.25.2.2	Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, тэдгээрийн ажилтнуудад танилцуулах, олон нийтэд сурталчлах,	Сургалтын тоо  Хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо	Хот байгуулалт, газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна.	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журамд орсон нэмэлт өөрчлөлт анхаарах асуудал, Газрын тухай, кадастрын зураглал ба газрын кадастрын тухай шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах зорилгоор танхимын болон 2 өдөр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан ажиллалаа. Хэрэгжилтийн хувь: 100%	

	мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах				
1.25.3	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах	Салбарын хэмжээнд 4761 мод	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, салбарын хэмжээнд тайланг нэгтгэн гаргасан байна.		
1.25.3.1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах	110 ш мод	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд 2023 оны хаврын тарилтаар 50 ширхэг мод бут тарих ажлыг 2023 оны 05 дугаар сарын 09-19-ний өдрүүдэд зохион байгуулсан. - 150 ширхэг бургас Хараагийн эрэг дээрхи өөрийн талбай дээр тарилт хийсэн нийт 2023 онд мод тарилтаар 300 ширхэг мод тарьсан. <a href="https://terbummod.mn/">https://terbummod.mn/</a> үндэсний хөдөлгөөний цахим сайтад бүртгүүсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
1.25.3.2	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зориулалтаар газар эзэмшүүлэх байршлыг тодорхойлж газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулах	Иргэн, аж хуйн нэгж, байгууллагад Мод үржүүлгийн зориулалтаар олгосон газрын тоо, хэмжээ	Шинээр тарьж, арчилж ургуулсан ой, модоор бүрхэгдсэн болон тохижилт хийсэн цэцэрлэгт хүрээлэн, гудамжны талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод тарих чиглэлээр 216,7 га газрыг төлөвлөгөөнд тусгасанаас 176 га газрыг 31 иргэн хуулийн этгээдтэй Дархан сумын засаг дарга хариуцлагын гэрээ байгуулан хувиарлалт хийсэн. Хараа голын эрэг дагуу мод тарих үржүүлэх чиглэлээр хариуцлагын гэрээ байгуулсан иргэн, аж ахуй нэгж байгууллагын гэрээний хэрэгжилтийн үр дүнг дүгнэх ажлын хэсэг байгуулагдаж, хяналт шалгалт, ажлын үр дүнг газар дээр нь дүгнэсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	

### ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин/ биелэлт	Үнэлгээ
-----	---	------------------	-----------------	------------------------	---------

2.1.1	Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ	Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн сангийн цахим үйлчилгээгээр хэрэглэгч байгууллага, иргэдийг хангах	21 аймаг, нийслэлийн 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зургийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна.		
2.1.1.1	1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг, мэдээллийн санг шинэчлэх	Мэдээллийн сан	21 аймгийн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлнө. 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн шинэчлэлтийн тайлан, мэдээг холбогдох журмын дагуу хагас болон бүтэн жилээр Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүргүүлсэн байна.	GNSS-ийн байнгын ажиллагаатай станцад тулгуулан геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд 16-н барилгын гүйцэтгэлийн зураг, 28-н инженерийн шугам сүлжээ, авто замын байгууламжийн тэг тэнхлэгийг газарт шилжүүлсэн ажлыг хүлээн авч мэдээллийн санд нийт 44 зургийг оруулж шинэчилсэн байна. 192.168.20.24 /Geodesy/ Дархан-Уул аймаг хавтсанд байршууллаа. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.1.2	Инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг шинэчлэх	Цахилгаан дамжуулах шугам; Ариутгах татуургын шугам, худаг; Дулаан дамжуулах шугам, худаг; Цэвэр усны шугам, худаг Харилцаа холбооны шугам, худаг; Ус зайлуулах шугам, худаг; Шилэн кабель;	21 аймаг, нийслэлийн инженерийн шугам сүлжээний зургийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлнө. Инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн тайлан, мэдээг холбогдох журмын дагуу хагас болон бүтэн жилээр Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүргүүлсэн байна.	Дархан-Уул аймгийн 2022 оны жижүүрийн хөтлөлтийн тайланг 2023 оны 3-р сард ГЗБГЗЗГ-т хүргүүлж 21 аймгийн хэмжээнд 2-р байранд үнэлэгдсэн. 2023 оны тайланд нийт 44 барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг төслийг хүлээн авсаны дагуу 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан тайланг ГЗБГЗЗГ-т хугацаанд нь хүргүүлнэ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.1.3	Байр зүйн зургийн шинэчлэлтийг шалгах ажлыг зохион байгуулах	21 аймаг 230 сум 45 суурин	Геопортал үндэсний цахим системд хөрвүүлсэн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн шинэчлэлтийг сансарын болон дроны зураг ашиглаж шалган, шинэчлэлтийн судалгаа гаргасан байна.	ГЗБГЗЗГ-аас Дроны зураг ирээгүй тул хийгдээгүй. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	

2.1.1.4	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх	Аймгийн цэг, тэмдэгтийн тоо	Геодезийн байнгын цэг тэмдэгтийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна.	Сумдын газрын даамлуудын өгсөн мэдээг нэгтгэн Дархан сум 48, Орхон сум 12, Шарын гол 4, Хонгор сум 60 нийт 125 цэг, 6 устсан цэгийн мэдээллийг цахим санд бүртгэлээ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.1.5	Бусад байгууллагын захиалгаар хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлын даалгаварт санал өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг шалгаж хүлээн авах	Геодези, зураг зүйн ажлын тоо	Геодези, зураг зүйн ажлын даалгаварт санал өгнө. Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг хүлээн авч. Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд актаар хүлээлгэн өгсөн байна.	Хонгор сумын төв, малын удмын сан, 3-н шар орчимд хийгдэх 1:1000 масштабтай байр зүйн зургийн ажлын даалгаварыг бичиж ерөнхий архитекторт хүргүүлсэн. Тус ажил нь гэрээ хийгдсэн боловч гүйцэтгэгч компаниас гэрээг цуцалсан байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.1.6	Бусад байгууллагын захиалгаар хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлын үр дүнг Геоорталд оруулах	Хүсэлтийн тоо	Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн аймаг, сумын төвийн байр зүйн зургийн шинэчлэлтийг Геоортал цахим системд оруулж хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Иргэн аж ахуйн нэгжийн захиалгаар хийгдсэн 5-н гүйцэтгэлийн зургийг хүлээн авч Геоортал цахим системд оруулсан <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.3	Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ	Монгол орны газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулж, хэрэглээнд гаргах	Геоортал цахим системд 2020-2021 онд гүйцэтгэсэн газар зүйн нэрийн мэдээллийн санг хүлээн авч нэрийн мэдээллийн системд оруулсан байна.		
2.1.3.1	Газар зүйн нэрийн мэдээллийн санг шинэчлэх	1 мэдээллийн сан	<b>Эхний хагас жилд:</b> Геоортал цахим системд аймгийн хэмжээний газар зүйн нэрийн мэдээллийг засварлаж оруулна. <b>Жилийн эцэст:</b> Геоортал цахим системд аймгийн хэмжээний газар зүйн нэрийн мэдээллийг засварлан оруулж, цахим үйлчилгээ нэвтрүүлнэ.	Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийг геоортал программд 2003 онд батлагдсан 1025 газар зүйн нэртэй тулгаж бүртгэж, баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Хонгор сум 609, Орхон сум 124 нийт 733 газар зүйн нэрийг геоортал мэдээлэн санд бүртгэлээ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.5	Хаягийн мэдээллийн системийг хөтлөх	Хаягийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа	Хаягийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.		
2.1.5.1	Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг аймгийн хэмжээнд зохион	Шинээр нэр, хаяг олгогдож, Хаягийн мэдээллийн санд	Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг аймгийн ерөнхий архитектортой хамтран аймгийн	Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн ахмад ажилтануудийн холбоо ТББ-аас “Ардын өргөн чөлөө”-ний гудамжийг Монгол улсын хөдөлмөрийн баатар, аж үйлдвэрийн гавьяат ажилтан П.Дамдин агсны нэрэмжит болгуулахаар	

	байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан гудамж, зам болон нэрэмжит болгосон талбайг мэдээллийн санд бүртгэх	бүртгэгдсэн гудамж, зам, талбайн тоо	хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулж, нэр олгогдсон, нэрэмжит болгосон талбай, гудамж, замыг хаягийн мэдээллийн санд бүртгэсэн байна.	санал ирүүлсэн. Үүний дагуу 16-н давхарыг урд талын замын уулзвараас аюулгүйн тойрог хүртлэх “Ардын өргөн чөлөө”-ний 1,2,3 дугаар гудамжийг дагууд нь П.Дамдин агсаны нэрэмжит болгож ИТХ-ын тогтоол гаргуулсан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.5.2	Кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй холбогдох хууль, журмын дагуу хаяг олгогдоогүй нэгж талбарт Хаягийн мэдээллийн системээр хаяг олгож, баталгаажуулах, тус системийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглах	Нэгж талбарын тоо	<b>Эхний хагас жилд:</b> Аймгийн хэмжээнд хаяг олгогдоогүй нэгж талбарын судалгааг бүрэн гаргасан байна. <b>Жилийн эцэст:</b>  Хаяг олгогдоогүй нэгж талбаруудад хаяг олгож баталгаажуулсан байна.	Хаягийн зургийн дагуу 114 гараж, 53 амины орон сууц, 9 нийтийн орон сууц, 5 үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. Орхон сумын ИТХ-ын 2023.09.27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор шинээр өмчлүүлэх 55 нэгж талбар, 138 өвөлжөө, хаваржаа, Хонгор сумын ИТХ-ын 2023.09.11-ны өдрийн 30 дугаар тогтоолоор 300 өвөлжөө, хаваржааны хаяг дугаарыг газар зүйн нэртэй уялдуулан хаяг дугаар олгож мэдээллийн санд бүртгэж баталгаажуулсан байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.6	<b>Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих</b>	<b>Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа</b>	<b>Газрын кадастрын мэдээллийн санг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.</b>	
2.1.6.1	Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүртгэж, оруулах	Цахим хувийн хэргийн тоо	Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүртгэж, Улсын бүртгэлд бүртгэсэн байна.	Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд 2055 нэгж талбарын цахим хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүртгэж, улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд бүртгэсэн. Үүнээс: ❖ Дархан сум-1382 ❖ Хонгор сум-439 ❖ Орхон сум-169 ❖ Шарын гол сум- 65 нэгж талбарыг тус тус газрын кадастрын нэгдсэн цахим системээр дамжуулан бүртгэлд оруулсан байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>

2.1.6.2	Цахим системд бүртгэгдсэн хүсэлтийг тухай бүр хянаж, баталгаажуулах, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Системд бүртгэгдсэн хүсэлтийн тоо	Газрын цахим системд бүртгэгдсэн хүсэлтүүд тухай бүр Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдэж, шийдвэрлэгдсэн байна.	Газар өмчлөх, эзэмших эрх шилжүүлэх, хамтран өмчлөгч хасуулах, хугацаа сунгах, шинээр газар эзэмших, өмчлөх, зориулалт өөрчлөх талбайн хэмжээ өөрчлөх, барьцаанд бүртгүүлэхээр нийт 2349 цахим хүсэлт ирсэнээс шаардлага хангаагүй 294 хүсэлт буцаагдаж, 2055 хүсэлтийг шийдвэрлэж мэдээллийн санд бүртгэж ажилласан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.6.3	Цахимаар ирсэн Газартай холбоотой зөрчлийг арилгах, холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх	Хүлээн авч шийдвэрлэсэн зөрчлийн тоо	Цахимаар болон гар утасны аппликейшнээр ирсэн газартай холбоотой зөрчлийг арилгаж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлсэн байна.	Өмчилсөн газраасаа илүү гаргаж зөвшөөрөлгүй хашаагаа сунгасан нийт 28 иргэний зөрчилтэй хүсэлт ирснээс 19 айлын хашааг татуулж зөрчлийг арилгуулаад байна. Үлдсэн 9 айлд цэг тогтоосон акт тавиулж хугацаатай шаардах хуудас хүргүүлэн арга хэмжээ авч ажилласан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.6.4	ГКМС-ийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа, дутагдлыг засварлах, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Засварлагдсан алдааны тоо	ГКМС-ийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа, дутагдлыг засварлаж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.	Газрын кадастрын мэдээллийн системд идэвхгүй буюу бүртгэлгүй байсан 216 нэгж талбарыг холбогдох журмын дагуу бүртгэж зөрчлийг арилгасан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>❖ Дархан сум-66</li> <li>❖ Хонгор сум -66</li> <li>❖ Орхон сум-71</li> <li>❖ Шарынгол сум 13 нэгж талбар</li> </ul> Мөн газар эзэмших гэрээний хугацаа буруу орсон-23 иргэн, аж ахуй нэгжийн регистрийн дугаар буруу бүртгэгдсэн-11, засаг даргын захирамжнаас ГКМС-д талбай хэмжээ зөрсөн-62, зориулалт өөрөөр бүртгэгдсэн-6, эзэмшил өмчлөлийн газар нь цуцлагдсан төлөвт орсон-19 өмчлөл эзэмшилийн давхар гэрээ үүссэн 106 гэрээг цуцлаж нийт 227 алдаа дутагдлыг засварлан хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.6.5	ГКМС-д бүртгэгдсэн Нууцын давхаргын мэдээллийг газар дээрх объекттай тулгах, шалгах ажлыг зохион байгуулах	Нууцын давхаргад бүртгэгдсэн нэгж талбарын тоо	ГКМС-д бүртгэгдсэн Нууцын давхаргын мэдээллийг газар дээрх объекттай тулгах, шалгах ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	ГКМС-д бүртгэгдсэн Нууцын давхаргын 5 мэдээллийг газар дээрх объекттай тулгах, шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	

2.1.6.6	Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын мэдээлэлд хяналт, тулгалт хийж зөрүүтэй мэдээллийг засварлах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангаж ажиллах	Орон нутгийн тусгай хэрэгцээний газрын тоо	Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын мэдээллийг нарийвчлан шалгаж үнэн зөв мэдээлэл бүртгэгдсэн байна.	Дархан-Уул аймгийн хэмжээнд 2015-2019 оны хооронд орон нутгийн тусгай хэрэгцээнд отрын бүсийн зориулалтаар 6, бичил уурхайн зориулалтаар 2, хадлангийн талбайн зориулалтаар 1, усны эрүүл ахуйн бүсээр 1 нийт 10 байршил бүхий 26613.3 га газрыг авсан байдаг. Үүнээс мэдээллийн санд зөрүүтэй мэдээлэл байхгүй. 2023 онд тус аймагт Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар байхгүй болно. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.6.7	Орон нутгийн тусгай хэрэгцээний газрыг Газрын кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулах	Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын тоо	Орон нутгийн тусгай хэрэгцээнд шинээр авсан газрыг кадастрын нэгдсэн системд тухай бүр бүртгэж, баталгаажуулсан байна.	2023 онд Дархан-Уул аймагт Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар байхгүй болно. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.7	<b>Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвөллөгөө өгөх, хяналт тавих</b>	<b>Нийслэл, 21 аймаг</b>	<b>Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.</b>	
2.1.7.1	Газрын төлбөр, татварын ногдуулалтыг Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээн авах ажлыг зохион байгуулах	Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн, системээс төлөлтийн мэдээлэл хүлээн авсан нэгж талбарын тоо	<b>Эхний хагас жилд:</b>  Хуульд заасан хугацаанд төлбөр, татварын ногдуулалтыг илгээх, төлөлтийн мэдээллийг цаг тухай бүр хүлээж авсан байна.	Аймгийн хэмжээнд 9237 гэрээнд 1,5 тэрбум төгрөгийн ногдол, нэхэмжлэл үүсгэж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна. Газрын төлбөр тайланд хугацаанд Дархан сум 956,3 сая, Орхон сум 25,4 сая, Хонгор 149,7 сая, Шарын гол 111,6 сая төгрөг нийт 2023 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар орон нутгийн төсөвт 1,243.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.7.2	Төлбөрийн даалгавар үүсгэн тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж, Татварын удирдлагын	Эрхийн харилцаанд орж байгаа нэгж талбарын тоо	<b>Эхний хагас жилд:</b>  Үйлчилгээ үзүүлсний тоогоор тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна.	Аймгийн хэмжээнд 443 тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэн Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна. Үүнд: Дархан сум 273, Хонгор 141, Орхон 22, Шарын гол 7 байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>

	нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулах			
2.1.7.3	Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх, газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг цахимаар авах үйлчилгээнүүдийн талаарх бүх боломжуудыг иргэд, олон нийтэд сурталчлах	Цахим системийн хэрэглээ	<b>Эхний хагас жилд:</b> Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх, газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг цахимаар авах боломжийг сурталчилсан байна.	Газрын төлбөр тушаах видео заавар хийж / <a href="https://www.youtube.com/watch?v=GaYcln-hHR0/">https://www.youtube.com/watch?v=GaYcln-hHR0/</a> -д 2023.03.23, 2023.05.12-ны өдөр байршуулж, олон нийтэд сурталчилсан. Мөн байгууллагын цахим хаягт сар болгон 2 удаа видео зааврыг байнгын хуваалцаж сурталчилж байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.7.4	Газрын зах зээлийн үнийн мэдээллийг Газрын үнэлгээний системд оруулах, дүн шинжилгээ хийх	Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо	<b>Эхний хагас жилд:</b> Хот, тосгон, бусад суурин газрын зах зээлийн үнийн мэдээллийг оруулсан байна. <b>Жилийн эцэст:</b> Тариалангийн газрын зах зээлийн үнийн мэдээллийг оруулсан байна.	Газрын биржийн цахим системээр нийт 323 үнийн мэдээ цуглуулж, газрын үнэлгээний системд оруулсан. Үүнд: Дархан сум 131, Орхон сум 63, Хонгор сум 114, Шарын гол сум 15 үнийн мэдээ оруулсан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.7.5	Хөдөө аж ахуйн газрын суурь үнэлгээ, үнэлгээний тойргийг шинэчлэн боловсруулах	Цуглуулсан зах зээлийн үнийн мэдээллийн тоо	<b>Эхний хагас жилд:</b> Хөдөө аж ахуйн газрын суурь үнэлгээ, үнэлгээний тойргийг шинэчлэх талаар мэдээлэл цуглуулж, санал боловсруулж, ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй ХАА-н газрын судалгааг гаргаж, нийт 39 нэгж талбарын үнийн мэдээ цуглуулж цахим биржид оруулсан. ГЗБГЗЗГ-аас ХАА-н газрын эдийн засгийн үнэлгээг хийх аргачлал тодорхой болоогүй байна. Аргачлал батлагдвал ХАА-н газрын үнэлгээг тооцоход бэлэн байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.7.6	Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах зохион байгуулах	Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо	<b>Эхний хагас жилд:</b> Тухайн жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөвлөсөн газарт зохион байгуулсан байна. <b>Жилийн эцэст:</b> Тухайн жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөвлөсөн газарт зохион байгуулсан байна.	Дархан-Уул аймгийн хэмжээнд 67 нэгж талбарт /Дархан сум 12, Орхон сум 15, Хонгор сум 38, Шарын гол сум 2 /эзэмших, ашиглах эрхийн газрын дуудлага худалдааг зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнээс аймгийн Засаг даргын 2023.03.22-ны өдрийн 01-А/64 дүгээр захирамжаар Дархан сумын 1 нэгж талбарт цахим дуудлага худалдааг 2023.04.24-ны өдөр зохион байгуулж орон нутгийн төсөвт 1.348.000.000 төгрөг, Орхон сумын Засаг даргын 2023.10.16-ны өдрийн 01-А/127 дугаартай захирамжаар 10 байршилд 2023.11.16-ны өдөр дуудлага худалдаа зарлагдсан боловч 7 нэгж талбарт оролцох хүсэлт ирүүлээгүй, 3 нэгж талбарт 3 хүсэлт ирж үнийн



				санал ирүүлээгүй учраас ялагч тодроогүй, Шарын гол сумын Засаг даргын 2023.10.17-ны өдрийн А/112 дугаартай захирамжаар 1 байршилд 2023.11.17-ны өдөр дуудлага худалдаа зохион байгуулагдаж Орон нутгийн төсөвт 729.000 төгрөг, Хонгор сумын Засаг даргын 2023.11.06-ны өдрийн 315 дугаартай захирамжаар 24 байршилд 2023.12.07-ны өдөр дуудлага худалдаа зарласан бөгөөд нийт 8 байршилд ялагч тодорч 198,276,200 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт орон нутгийн төсөвт дуудлага худалдааны орлогоос 1,547.005.200 төгрөг төвлөрүүлсэн байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.7.7	Газар өмчлөгч, эзэмшигчийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар худалдах хүсэлтийн дагуу дуудлага худалдаа зохион байгуулах	Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн тоо	<b>Эхний хагас жилд:</b> Газар өмчлөгч, эзэмшигчийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар худалдах хүсэлтийн дагуу дуудлага худалдаа зохион байгуулсан байна. <b>Жилийн эцэст:</b> Газар өмчлөгч, эзэмшигчийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар худалдах хүсэлтийн дагуу дуудлага худалдаа зохион байгуулсан байна.	Дархан-Уул аймагт Газар өмчлөгч, эзэмшигч газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар худалдах хүсэлт ирээгүй болно. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
2.1.7.8	Газрын биржийн цахим системээр дамжуулан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, олон нийтэд үйлчлэх	Эрх шилжсэн нэгж талбарын тоогоор нэмж бүртгэсэн үнийн мэдээ	<b>Эхний хагас жилд:</b> Газрын эрх шилжсэн нэгж талбарын тоогоор газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын биржийн цахим системд бүртгэсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Газрын эрх шилжсэн нэгж талбарын тоогоор газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын биржийн цахим системд бүртгэсэн байна.	Газрын биржийн цахим системээр нийт 323 үнийн мэдээ цуглуулж, газрын үнэлгээний системд оруулсан. Үүнд: Дархан сум 131, Орхон сум 63, Хонгор сум 114, Шарын гол сум 15 үнийн мэдээ оруулсан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>

2.1.8	Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих	Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагаа	Газрын нэгдмэл сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.		
2.1.8.1	Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгаж, Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулах ажлыг зохион байгуулах	Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажсан нэгж талбарын тоо	<p><b>Эхний хагас жилд:</b> Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна.</p>	<p>Газрын кадастрын мэдээллийн системд идэвхгүй буюу бүртгэлгүй байсан 216 нэгж талбарыг холбогдох журмын дагуу бүртгэж зөрчлийг арилгасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Дархан сум-66</li> <li>❖ Хонгор сум -66</li> <li>❖ Орхон сум-71</li> <li>❖ Шарынгол сум 13 нэгж талбар</li> </ul> <p>Дархан-Уул аймгийн хэмжээнд цахим болон гар утасны аппикейшинээр ирсэн газартай холбоотой зөрчил арилгах ажлын хүрээнд 28 иргэн, аж ахуй нэгж байгууллагад хугацаатай шаардах хуудас хүргүүлэн Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-т заасны дагуу газар чөлөөлөх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулан ажилласан. Үүнээс 19 нэгж талбарын зөрчлийг арилгуулан газрын кадастрын системд баталгаажуулсан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>	
2.1.8.2	Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажиллах	Төрийн өмчийн газрын хариуцагчтай байгуулсан гэрээний тоо	<p><b>Эхний хагас жилд:</b> Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Төрийн өмчийн газрын хариуцагчтай байгуулсан гэрээг мэдээллийн санд баталгаажуулсан байна.</p>	Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулах журам боловсруулагдаж ирээгүй учраас хэрэгжих боломжгүй байна. /Биелэлтээс хассан/	
2.1.8.3	Харьяалах нутаг дэвсгэрийн гадна олгосон иргэн, хуулийн этгээдийн газрыг холбогдох хууль, журмын дагуу	Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн нэгж талбарын тоо	<p><b>Эхний хагас жилд:</b> Засаг даргын харьяалах нутаг дэвсгэрийн гадна олгосон иргэн, хуулийн этгээдийн газрыг харьяа нутаг дэвсгэрт олгох ажлыг зохион байгуулсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b></p>	<p>2023 онд аймаг сумын засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийн гадна газар олголт хийгээгүй болно. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>	

	шийдвэрлэх ажлыг зохион байгуулах		Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна.		
2.1.8.4	Газрын нэгдмэл сангийн цахим системд өөрчлөлтийг оруулах, системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах	Газрын нэгдмэл сангийн цахим системийн үйл ажиллагаа	<p><b>Эхний хагас жилд:</b> Газрын нэгдмэл сангийн цахим системд газрын нэгдмэл сангийн ангилалд өөрчлөлт орсон тухай бүх өөрчлөлтийг оруулж, системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Газрын нэгдмэл сангийн цахим системд газрын нэгдмэл сангийн ангилалд өөрчлөлт орсон тухай бүх өөрчлөлтийг оруулж, системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.</p>	<p>2022 оны Газрын нэгдмэл сангийн тайланг 2023 оны 1 сард аймгийн ИТХ-аар батлагдан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Үүнд: Дархан сум 9813 га, Хонгор сум 263957 га, Орхон сум 44177 га, Шарын гол 9553 га, аймгийн нийт нутаг дэвсгэр 327500 га байна.</p> <p>Тухайн жилд орсон өөрчлөлт орсон ангиллыг харуулвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ ХАА-н газар 332.96 га газраар хасагдсан</li> <li>❖ Хот тосгон, бусад суурины газарт 196.15 га газраар нэмэгдсэн</li> <li>❖ Зам, шугам сүлжээний газар 5.28 га газраар нэмэгдсэн</li> <li>❖ Ойн сан бүхий газарт 52.33 га газраар нэмэгдсэн</li> <li>❖ Усан сан бүхий газарт өөрчлөлт ороогүй</li> <li>❖ Улсын тусгай хэрэгцээний газарт 79.2 га газраар нэмэгдсэн.</li> </ul> <p>Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд газрын нэгдмэл сангийн ангилалд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг оруулж, мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>	
2.1.9	Салбарын хэмжээнд сүлжээ, техник, програм хангамж, системийн хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах	Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа	Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна.		

2.1.9.1	Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах	Байгууллагын сүлжээний төхөөрөмж болон Газрын даамлуудын VPN тусгаарласан сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа	Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангасан байна.	Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ тасалдалгүй хэвийн ажилласан. Барилга, хот байгуулалтын хэлтэс, захиргаа, улсын байцаагч нарын өрөө, санхүүгийн өрөөнд 2 удаа, даамлуудад 2 удаа сүлжээний холболтыг өгөв. ГЗБГЗЗГ-аас байгууллагын бүх компьютерт хорт кодоос сэргийлэх програмыг автоматаар шинэчлэн уншуулахад алдаа гарч уншаагүй 7 компьютерт гараар суулгав. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.9.2	Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах	Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа	Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангасан байна.	Серверийн өрөөний агааржуулагчны усыг асгаж цэвэрлэн, серверийн өрөөнд цэвэр агаар оруулж цэвэрлэгээг тогтмол хийсэн. Техник хангамжийн гэмтэл гарсан 2 компьютерийг засварын газарт засварлуулан, эх хавтанг солиулж, холбож өгөв. Техник хангамжийн гэмтэл гарсан 1 компьютерийн гэмтлийг засварлав. 1 компьютерт нэмэлтээр SSD диск суурилуулав. 6 компьютерийг 2 удаа форматлаж, үйлдлийн систем суулгаж, шаардлагатай хэрэглээний програмуудыг суулгаж, хэвлэгч, сканер таниулан, VPN холболтын тохиргоог хийж өгөв. 7 компьютерт хэрэглээний програмууд, QGIS суулгаж, хэвлэгч, сканер таниулав. 4 компьютерт хэвлэгч, 2 компьютерт сканер таниулж өгөв. 5 компьютерт сүлжээний болон VPN-ийн тохиргоог хийв. Албаны цахим шуудангийн нууц үгээ мартсан 7 албан хаагчийн нууц үгийг сольж, ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчийн цахим шуудангийн эрхийг устгаж, 2 албан хаагчийн төлвийг өөрчилж, шинээр ажилд орсон 7 албан хаагчид хаяг нээж, хэрэглэгчдийн мэдээлэлд шинэчлэлт хийв. Апле систем дээр 3 албан хаагчийг чөлөөлж, 3 албан хаагчийн төлөвт өөрчлөлт оруулж, 4 албан хаагчийг шинээр бүртгэж, хэрэглэгч үүсгэн, хүний нөөцийн мэдээллийг оруулж, тохиргоог хийв. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	

2.1.10	Байгууллагын болон салбарын үйл ажиллагаанд шаардлагатай веб хуудас, программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх хэрэглээнд нэвтрүүлэх	3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт	3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.		
2.1.10.1	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем /Геопортал/-ийн дэд санг стандартын дагуу бүрдүүлэх	Дэд сан бүрээр бүрдүүлсэн өгөгдлийн тоо	Геопорталын Геодезийн цэг тэмдэгт, Байр зүйн, Хаяг, Барилга, суурин газрын дэд санг стандартын дагуу баяжуулж, бүрдүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хамаарах Хонгор сум 609, Орхон сум 124 нийт 733 газар зүйн нэр, 16 барилга, 19 инженерийн шугам сүлжээ, 9 авто замын байгууламжийн ажлыг геопортал мэдээллийн санд бүртгэсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.12	Салбарын архивын баримтаар хэрэглэгчдэд үйлчлэх	Цаасан болон цахим баримтын үйлчилгээ	Цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна.		
2.1.12.1	Архивын баримтаар байгууллага, иргэдэд цахим үйлчилгээ үзүүлэх, лавлагаа мэдээлэл олгох.	Ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлчилгээ үзүүлэх	Ирүүлсэн хүсэлтийн дагуу цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна.	Архивын баримтаар хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд 24 ААНБ, 6 иргэнд архивын баримтыг хуулбарлан авах хүсэлтийн дагуу үйлчилгээ үзүүлсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.13	Төрийн архивын стандарт орчныг сайжруулах	Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа	Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.		
2.1.13.1	Дансны бүртгэл, хадгаламжийн сангийн өөрчлөлт, хөдөлгөөний бүртгэл хөтлөх, статистик мэдээ тайлан, тоо бүртгэлийн мэдээллийг гаргах	Мэдээ	<b>Жилийн эцэст:</b> Архивт хадгалагдаж байгаа баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, өөрчлөлт, хөдөлгөөний мэдээлэл болон нэгж талбарын хувийн хэргийн судалгааг загварын дагуу гаргаж, 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	2023.11.06-ны 1/2409 дугаартай албан бичигт зааврын дагуу ГЗБГЗЗГ-т хариу судалгааг хүргүүлсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
		Санал	<b>Эхний хагас жилд:</b>		

2.1.13. 2	Архивын хадгаламжийн санг зориулалтын шүүгээ, тавиур, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах талаар санал тавьж шийдвэрлүүлэх		Архивын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт орчныг бүрдүүлэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох зардлын тооцоо гарган удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. <b>Жилийн эцэст:</b> Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авсан байна.	Архивын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт орчныг бүрдүүлэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох зардлын тооцоо гарган удирдлагад танилцуулсан. Аймгийн Засаг даргын тамгын газраас 4 Архивын сейф /шүүгээ/ авсан 3-ыг нь угсарсан зориулалтын дагуу ашиглаж байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.14	<b>Геодезийн хэмжилтийн багаж баталгаажуулалтын лабораторийн үйл ажиллагааг сайжруулах</b>	<b>Баталгаажуулсан багажны тоо</b>	<b>2023 онд улсын хэмжээнд 1540 багажийг баталгаажуулсан байна.</b>		
2.1.14. 1	Аймгийн ГХБХБГ-т хэрэглэж буй геодезийн хэмжлийн багажийг баталгаажуулах	3 багаж	2022 онд баталгаажуулалт хийлгэсэн хугацаанд, бүх багажуудыг бүрэн хамруулсан байна.	2023 оны 12 сарын 15-нд баталгаажуулалт хийсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.17	<b>Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах</b>	<b>Иргэн, хуулийн этгээдийн тоо</b>	<b>Эрсдэл үүсэх магадлалыг бууруулсан байна</b>		
2.1.17. 1	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.	2023 онд 1 иргэн, 14 хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгууллаа. Мөн 5 аж ахуй нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч дүгнэлт гаргасан байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
2.1.17. 2	Газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдийн	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийн тоо	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу 5-н иргэний газарт хяналтийн хэмжилт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар 4 аж ахуйн нэгж их эрсдэлтэй үнэлгээтэй, 2 аж ахуйн нэгж байгууллага дунд эрсдэлтэй	

	хүсэлтээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх			үнэлгээтэй, хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудсаар 1 байгууллага их эрсдэлтэй, 2 байгууллага дунд эрсдэлтэй, 3 байгууллага бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Хяналт шалгалтаар Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт 71.2%, ХАБЭА-ийн хуулийн хэрэгжилт 42.3%-тэй шалгагдлаа. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
--	---	--	--	--

**ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин/ биелэлт	Үнэл-гээ
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1</b> <b>Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.</b>					
3.1.1	<b>Газар зүйн нэрийн тодруулалт</b>				
3.1.1.1	Газар зүйн нэрийн тодруулалт хийх	Сумын ТОО	<b>Эхний хагас жилд:</b> Орон нутгийн төсөвт тусгагдсан аймаг, сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаврыг ГЗБГЗЗГ-тай хамтран боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна. Газар зүйн нэрийн тодруулалт хийсэн ажлын үр дүнг УИХ-аар батлуулахад шаардлагатай холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Газар зүйн нэрийн тодруулалт хийсэн ажлын үр дүнг УИХ-аар батлуулахад шаардлагатай холбогдох баримт бичгийг	Газар зүйн нэрийн тодруулалтын мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаврыг ГЗБГЗЗГ-ын Геодези, зураг зүйн хэлтэстэй хамтран боловсруулсан. Дархан-Уул аймгийн 4 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 3.3 мянган км.кв талбайд нийт 1841 газар зүйн нэрийг тодруулах ажил хийгдэх шаардлагатай байгаа. 2023 оны орон нутгийн төсөвт нэрийн тодруулалт хийлгэх хөрөнгө мөнгө тусгуулах саналыг хүргүүлсэн боловч батлагдаагүй. 2024 оны орон нутгийн төсөвт суулгуулсан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	

			бүрдүүлэн ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	
3.1.1.2	Газар нэрийн тодруулалтын ажлын төсвийг батлуулах	Нийслэл, 19 аймаг	<p><b>Эхний хагас жилд:</b> Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын зардлыг орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын үр дүнг гүйцэтгэгчээс ирүүлсэн тухай бүрд хүлээн авч, Газар зүйн нэрийн зөвлөлийн хуралд танилцуулсан байна.</p>	<p>Дархан-Уул аймгийн 4 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 3.3 мянган км.кв талбайд нийт 1841 газар зүйн нэрийг тодруулах ажил хийгдэх шаардлагатай 82,3 сая төгрөгийг Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 123-р тушаалаар батлагдсан “Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ БД81-103-21”-ийн баримтлан 2024 оны орон нутгийн төсөвт суулгуулсан.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
3.1.1.3	Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах	Нийслэл, дүүрэг, 21 аймаг 330 сум 2 удаа хурал зохион байгуулах	<p><b>Эхний хагас жилд:</b> Газар зүйн нэрийн салбар асуудлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, 1 удаагийн хурлыг зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>“Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийн 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан уг салбар зөвлөлийн гишүүдээс санал авахаар төлөвлөгөөний төслийг хүргүүлсэн. Салбар зөвлөлийн хурлыг төлөвлөгөөнд тусгах саналыг хүлээн авсаны дараа хуралдуулахаар хүлээгдэж байна.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 80%</i></p>
3.1.2	<b>Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах</b>			
3.1.2.1	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн нэг цэгийг төлөөлөх талбайн хэмжээг нарийвчлан зураглаж гаргах, мониторингийн нэг цэгт байгаа малын тоо толгойн мэдээг гаргаж, газрын мониторингийн мэдээллийн санд	1 тайлан	<p><b>Эхний хагас жилд:</b> 2022 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлсэн ажлын үр дүнг үндэслэн холбогдох хүргүүлсэн дүгнэлт, санал, зөвлөмж, чиглэлийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.</p> <p>Хэрэгжүүлсэн ажлын талаар биелэлт гаргаж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн нэг цэгийн төлөөлөх талбайн хэмжээг ЛМ программд нарийвчлан зурагласан. 2022 оны бэлчээрийн газрын фото мониторингийн үр дүнг үндэслэн санал зөвлөмжийн дагуу Орхон сум 13 га газрыг бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан. Хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхээр иргэн, аж ахуй нэгжид хамгаалуулах гэрээг байгуулаад байна.</p>



	оруулахад бэлтгэх, хээрийн судалгааны ажлыг зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж, ажлын хэсэг байгуулах			Бэлчээр хамгаалах нөхөн сэргээх ажлын тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
3.1.2.2	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах	Аймгийн хэмжээнд байгуулсан мониторингийн цэгийн тоо	<b>Жилийн эцэст:</b> Аймаг, сумын хэмжээнд бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хээрийн судалгааны ажлыг 8 сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж, мониторингийн мэдээллийн санд оруулж, 10 сарын 01-ний өдрийн дотор ажлын үр дүнг нэгтгэсэн тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Дархан-Уул аймгийн Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг 8 дугаар сарын эхний 7 хоногт нийт 26 цэгт хийж, тайланг 2023 оны 10 дугаар сарын эхний 7 хоногт багтаан хүргүүлсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
3.1.2.3	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын 2023 үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэж, холбогдох хурлуудаар хэлэлцүүлэх, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах	Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэг	<b>Жилийн эцэст:</b> Аймгийн хэмжээнд нэгтгэсэн үр дүнг холбогдох хурлуудаар хэлэлцүүлэх, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан байна. Хэрэгжүүлсэн ажлын талаар биелэлт гаргаж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх 2023 оны ажлын тайланг бичиж хүргүүлсэн, Суурь судалгаа газрын мониторингийн хэлтсээс шалгаж буцаагдсан алдаануудыг системд засварлан хүргүүлсэн. Орхон, Хонгор сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 4 болон 5 дугаар зэргийн доройтсон бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээгээр тусгуулахаар саналыг хүргүүлээд байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
3.1.3	Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах	Төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгаа хийгдсэн тоо	Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг зохион байгуулахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, хянан баталгааны үр дүнг мониторингийн цахим системд оруулсан байна.		
			Эхний хагас жилд:		

3.1. 3.1	Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, цахимаар болон хэвлэмэл байдлаар ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах	Захиалгат хянан баталгаа хийж, баталгаажсан тайлан, дүгнэлтийн тоо	<p>Цахим системээр хянан баталгааны тайлан, дүгнэлтийг баталгаажуулахад гарч буй алдаа, зөрчлийг засварлаж, тайлангийн үр дүнг сайжруулах, тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулсан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгааны үр дүнгээр илэрсэн хөрсний бохирдол, доройтолд өртсөн газруудын судалгааг гаргаж, бохирдол, доройтолд өртсөн газруудад хариу арга хэмжээ авсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b></p> <p>Цахим системээр хянан баталгааны тайлан, дүгнэлтийг баталгаажуулахад гарч буй алдаа, зөрчлийг засварлаж, тайлангийн үр дүнг сайжруулах, тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулсан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгааны үр дүнгээр илэрсэн хөрсний бохирдол, доройтолд өртсөн газруудын судалгааг гаргаж, бохирдол, доройтолд өртсөн газруудад хариу арга хэмжээ авсан байна.</p>	<p>Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны тайланг Газрын мониторингийн цахим системээр хүлээн авч шалгаж ажиллаж байна. 2023.11.28-ны өдрийн байдлаар 754 захиалгат хянан баталгааны тайланг цахимаар хянаж, 731 тайлан баталгаажиж, 23 тайлан хянаж буцаагдсан байна.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
3.1. 3.2	Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх	Орон нутгийн төсвөөр хийгдсэн ажлын тоо	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <p>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгаа хийгдэх газруудын судалгааг гаргаж, ажлын даалгаврыг боловсруулж ГЗБГЗЗГ-аас санал авсан байна. Мөн газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны</p>	<p>ГЗБГЗЗГ-н 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1047 тоот албан бичгээр 2024 онд орон нутгийн төсвөөр хийгдэх хянан баталгааны ажлыг зохион байгуулахаар төлөвлөн орон нутгийн төсөвт тусгах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэсэн чиглэлийн дагуу Хонгор, Шарын гол сумдын шинээр өмчлүүлэх газрын хянан баталгааны ажлыг Эхлэх цэг хангай ХХК-аар хийлгэхээр ажлын даалгавар боловсруулан хүргүүлээд байна.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>

			<p>ажлын эцсийн шатны тайланд хяналт тавьж ажилласан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын эцсийн шатны тайланг хянаж, ажлын үр дүн, тоон мэдээллийг гүйцэтгэгч байгууллагаар газрын мониторингийн цахим системд оруулсан эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.</p>	
<b>3.1.4</b>	<b>Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх</b>			
3.1.4.1	Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх, сумын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах	Батлуулсан төлөвлөгөөний тоо	<p><b>Эхний хагас жилд:</b> 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хээрийн судалгаа, хэмжилтүүдийг хийсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хээрийн судалгаа, хэмжилтүүдийг хийж, нарийвчилсан зураг төслийг боловсруулсан байна. 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, сум, дүүргийн ИТХ-аар батлуулсан байна.</p>	<p>2023.03.22, 2023.11.15-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын газрын даамлуудад газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч танхимийн сургалт зохион байгууллаа.</p> <p>Газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим системд Дархан 2024-07-045-7256, Орхон 2024-07-045-7257, Хонгор 2024-07-045-7258, Шарын гол 2024-07-045-730 дугаартай төслүүд үүсгэн, аймгийн хэмжээнд цахим болон цаасаар нийт 213 санал хүлээн авсан байна.</p> <p>2023 оны 12 дугаар сарын 19-нд багтаан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
3.1.4.2	Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт тогтоох тухай Засгийн газрын 2023 оны тогтоолын хэрэгжилтийн явцын тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоосон Засгийн газрын тогтоол	<p><b>Эхний хагас жилд:</b> Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт тогтоох тухай Засгийн газрын 2023 оны тогтоолын эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын тайланг 6 сард ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b></p>	<p>Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 22-ны 105 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нийт 117.02 га газрыг өмчлүүлэхээр батлагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Дархан сумын ИТХ-ын 2022 оны 22 дугаар тогтоолоор эзэмшиж буй газраа өмчлөх 988 иргэнд 79,72 га тусгагдсанаас Эзэмшиж байгаа газраа өмчлөх 28 иргэнд 2.42 га газар өмчлүүлсэн байна.</li> </ul>

			Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт тогтоох тухай Засгийн газрын 2023 оны тогтоолын жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>❖ Орхон сумын ИТХ-ын 2022 оны 28 дугаар тогтоолоор 55 иргэнд 3,95 га газрыг өмчлүүлэхээс 100 хувь өмчлүүлсэн.</li> <li>❖ Шарын голын сумын ИТХ-ын 2022 оны 22 дугаар тогтоолоор 36 иргэнд 2,5 га газрыг 100 хувь өмчлүүлсэн.</li> <li>❖ Хонгор сумын ИТХ-ын 2022 оны 30 дугаар тогтоолоор 279 иргэнд 29,92 га газрыг өмчлүүлэхээс 236 иргэнд 21.8 га газрыг тус тус өмчлүүлсэн. Нийт аймгийн хэмжээнд 355 иргэнд 30,67 га газрыг өмчлүүлсэн.</li> </ul> <p>Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт тогтоох тухай Засгийн газрын 2023 оны тогтоолын жилийн эцсийн хэрэгжилтийг Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим системд оруулж, ГЗБГЗЗГ-аас 12 сарын 1-ний өдрийн байдлаар татан авсан. Хэрэгжилтийн хувь: 100%</p>
3.1.4.3	Аймгийн хэмжээнд 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлж ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал	<p><b>Эхний хагас жилд:</b> Аймгийн хэмжээнд 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлын судалгаа, хэмжилтүүдийг хийж, нарийвчилсан зураг төслийг боловсруулж, 2024 оны иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналын төслийг бэлтгэсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Аймгийн хэмжээнд 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг ИТХ-аар хэлэлцүүлж 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>Аймгийн хэмжээнд 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлын судалгаа гаргаж Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулсан.</p> <p>2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг ИТХ-аар хэлэлцүүлж 2023 оны 9 сарын 28-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор 2222 иргэнд 220 га газрыг өмчлүүлэхээр батлуулсан. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дархан сум 2023.09.22-ны өдрийн 11 тогтоолоор 742 иргэнд 62.56 га</li> <li>- Хонгор сум 2023.09.11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор 1265 иргэнд 134.35 га</li> <li>- Орхон сум 2023.09.27-ны 14 дүгээр тогтоолоор 202 иргэнд 21.99 га</li> <li>- Шарын гол 2023.09.29-ны 40 дүгээр тогтоолоор 13 иргэнд 1.1 га тус тус өмчлүүлэхээр батлуулж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.</li> </ul> <p>Хэрэгжилтийн хувь: 100%</p>
3.1.4.4	Сумын 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын	Бүх сум	<p><b>Эхний хагас жилд:</b> 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний</p>	<ul style="list-style-type: none"> <li>❖ Дархан сумын ИТХ-ын 2022 оны 32 дугаар тогтоолоор 366.02 га, нэмэлт 2 удаа тодотгол оруулж</li> </ul>

	<p>төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих</p>		<p>хэрэгжилтэд хяналт хийж тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.  <b>Жилийн эцэст:</b>          2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хийж тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>сумын ИТХ-ын 2023 оны 10, 12 дугаар тогтоолоор батлуулсан.          ❖ Орхон сумын ИТХ-ын 2022 оны 32 дугаар тогтоолоор 55.35 га, Нэмэлт нэг удаа тодотгол оруулж сумын ИТХ-ын 2023 оны 10 тогтоолоор батлуулсан.          ❖ Шарын голын сумын ИТХ-ын 2022 оны 27 дугаар тогтоолоор 67 га, Нэмэлт нэг удаа тодотгол оруулж сумын ИТХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлуулсан.          ❖ Хонгор сумын ИТХ-ын 2022 оны 43 дугаар тогтоолоор 962,9 га, нэмэлт 2 удаа тодотгол оруулж сумын ИТХ-ын 2023 оны 15, 26 дугаар тогтоолоор батлуулж Газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим системд оруулсан          Үүнээс хэрэгжилт нь:          - Дархан сум 16 арга хэмжээгээр 289 нэгж талбарын 365,2 га төлөвлөснөөс 213 нэгж талбарын 200,84 га хэрэгжиж 73,7 хувьтай биелсэн байна.          - Орхон сум 10 арга хэмжээгээр 68 нэгж талбарын 56,83 га газар төлөвлөснөөс 24 нэгж талбарын 25,24 га хэрэгжиж 35,3 хувьтай биелсэн байна.          - Шарын гол сум 8 арга хэмжээгээр 33 нэгж талбар төлөвлөснөөс 32 нэгж талбар хэрэгжиж 96,7 хувьтай биелсэн байна.          - Хонгор сум сум 22 арга хэмжээгээр 558 нэгж талбар төлөвлөснөөс 250 нэгж талбар хэрэгжиж 44,8 хувьтай биелсэн байна.          Аймгийн хэмжээнд тухайн жилийн төлөвлөгөөнд нийт 43 арга хэмжээ хэмжээгээр 948 нэгж талбар төлөвлөгдөж 31 арга хэмжээний 519 нэгж талбар хэрэгжүүлж төлөвлөгөөний биелэлт 54,74 хувийн биелэлттэй байна. Хэрэгжилтийн тайланг хугацаанд нь ИТХ-ын тогтоолын хамт хүргүүлнэ.  <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>	
<p>3.1.6</p>	<p><b>Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах</b></p>				
<p>3.1.6.1</p>	<p>Газрын нэгдмэл сангийн 2022 оны тайланг сумдаас авч нэгтгэн, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх</p>	<p>Газрын нэгдмэл сангийн 2022 оны тайлан</p>	<p><b>Эхний хагас жилд:</b> Газрын нэгдмэл сангийн 2022 оны тайланг хүлээн авч нэгтгэн, 2023 оны 01 сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>Газрын нэгдмэл сангийн 2022 оны тайланг сумдаас авч нэгтгэн, тайлант хугацаанд нь ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. 2023 оны тайланг 2024 оны 1 сарын 15-ны дотор хүргүүлнэ.  <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>	

3.1.6.2	Байгаль орчны төлөв байдлын БОХ-1.2 тайланг гаргаж аймгийн хэмжээнд нэгтгэж, агентлагт хүргүүлэх	2021 оны БОХ-1.2 тайлан	<b>Эхний хагас жилд:</b> Аймгийн хэмжээнд 2022 оны БОХ 1.2 тайланг гаргаж, чанартай нэгтгэн ГЗБГЗЗГ-т 2023 оны 01 сарын 15-ны өдрийн дотор хүргүүлсэн байна.	Байгаль орчны төлөв байдлын БОХ-1.2 тайланг нэгтгэж 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. 2023 оны тайланг 2024 оны 1 сарын 15-ны дотор хүргүүлнэ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1.6.3	Газрын нэгдмэл сангийн 2022 оны Газарт учирсан хохирлын тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн, агентлагт хүргүүлэх	Газрын нэгдмэл сангийн 2022 оны Газарт учирсан хохирлын тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан	<b>Эхний хагас жилд:</b> Газрын нэгдмэл сангийн 2022 оны улсын нэгдсэн тайланд Газарт учирсан хохирлын ГТ-6 тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ГТ-7 тайланг чанартай нэгтгэн гаргаж, ГЗБГЗЗГ-т 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлсэн байна.	Газрын нэгдмэл сангийн 2022 оны нэгдсэн тайлангийн Газарт учирсан хохирлын ГТ-6 тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ГТ-7 тайланг нэгтгэн гаргаж 2023 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. 2023 оны тайлан илгээх хугацаа болоогүй. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1.6.4	Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн цахим системээс гаргахад мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр сумдын газрын даамлуудыг хангаж ажиллах	Газрын нэгдмэл сангийн тайлан	<b>Жилийн эцэст:</b> Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн цахим системээс гаргахад мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангагдсан байна.	Сумдын даамал нарт 2023 оны 11 сарын 08-нд танхимаар, 11 сарын 20-нд цахимаар Газрын нэгдмэл сангийн тайланг шинэчлэгдсэн маягтын дагуу гаргах мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1.6.5	“Газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх журам” болон тайлангийн маягтууд, “Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам”, “Газрын нэгдмэл сангийн цахим системээс тайлан гаргах заавар”-ыг сумдад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Сумдын тоо	Шинэчлэн батлагдсан журам, заавар, тайлангийн маягтуудыг сумдад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан байна.	Системээс гарах ажил бүрэн дуусаагүй учир уламжлалт аргаар гаргаж 2024 оны 1 сарын 15-ны дотор хүргүүлнэ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1.8	<b>Салбарын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах</b>			
3.1.8.1	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт	Үүсгэсэн хадгаламжийн нэгжийн тоо	<b>Эхний хагас жилд:</b> . Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авсан байна.	Геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн 16 улаан шугам болон 5 гүйцэтгэлийн зураглалыг мэдээллийн санд бүртгэж, хүлээн авсан.

	ирүүлсэн ажлыг хүлээн авах		<b>Жилийн эцэст:</b> Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон гэрээт ажлын хүрээнд хийж төрийн архивт ирүүлсэн ажлыг хүлээн авсан байна	<i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1.8.2	Аймгийн ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэргийг сумдаас татан төвлөрүүлэх	Татан төвлөрүүлсэн нэгж талбарын хувийн хэргийн тоо	<b>Эхний хагас жилд:</b> Орхон сумын 1000 хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Орхон сумын 2104 хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Эхний хагас жилд Орхон сумын хувийн хэргийг татахаар төлөвлөсөн боловч нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн ажлаас шалтгаалж хойшилсон. Архивын ажилтан 9-р сараас ажиллаж эхэлсэн тул нэгж талбарын хувийн хэрэгтэй ажиллах дүрэм заавартай танилцаж, зөвлөмж өгч ажилласан. Одоогийн байдлаар 700 орчим Дархан сумын нэгж талбарын хувийн хэргийг цэгцлэх ажил гүйцэтгэсэн байна. Дадлага туршлага суусны дараагаар ирэх оны 1-р улирлаас хувийн хэрэг татан авалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. <i>Хэрэгжилтийн хувь: 80%</i>
<b>3.1.9</b>	<b>Хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт</b>			
3.1.9.1	Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын үйл ажиллагааны тухайн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	Тайлан-1	<b>Эхний хагас жилд:</b> Аймгин ерөнхий архитекторуудын 2022 оны үйл ажиллагааны тайланг гарган, үйл ажиллагааг үнэлж, 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Дархан-Уул аймгийн ерөнхий архитекторын 2022 оны үйл ажиллагааны тайланг 2023 оны 3-р сард ГЗБГЗЗГ-т хүргүүлж 21 аймгийн хэмжээнд 2-р байранд үнэлэгдсэн. 2023 оны тайланг 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан хугацаанд нь хүргүүлнэ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1.9.2	Хот, суурин газрын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу "Хот суурин газрыг	Аймгийн төвийн сум	<b>Эхний хагас жилд:</b>	Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот суурин газрыг хөгжүүлэх, дахин төлөвлөх, барилгажуулах, арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох хууль дүрмийн дагуу боловсруулан баталгаажуулахаар хүргүүлсэн.

	<p>хөгжүүлэх арга хэмжээний дөрвөн жилийн төлөвлөгөө"-г улс, орон нутгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсэгт зааснаар боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж эхлүүлэх</p>		<p>“Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулан батлуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар эхлүүлсэн байна.</p>	<p>“Хот суурин газрыг хөгжүүлэх арга хэмжээний дөрвөн жилийн төлөвлөгөө”-ний хүрээнд 2020 он 7 сарын 30-ны өдрийн Аймгийн ИТХ-н тэргүүлэгчдийн 68 дугаар тогтоолоор “Дахин хөгжүүлэх төсөл” дахин төлөвлөлтөөр хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга, байгууламжийг буулган шинээр барилгажуулах газрын байршлыг төлөвлөн, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.</p> <p>2023 онд 8 байршилд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах, хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөх зургийн даалгаврыг боловсруулан батлуулж төлөвлөлтийн ажлыг эхлүүлсэн.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>	
<p>3.1. 9.3</p>	<p>“Хот байгуулалтын тухай” хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу орон нутгийн захиалгаар хийгдэх хот байгуулалтын баримт бичиг боловсруулах зургийн даалгаврын төслийг ГЗБГЗЗГ-аар хянуулан баталгаажуулах</p>	<p>Зөвшилцсөн зургийн даалгаврын тоо</p> <p>сумд</p>	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <p>Зургийн даалгаварт хур тундасны усыг хуримтлуулан хиймэл нуур, хөв цөөрөм, усан сан байгуулах замаар тоосжилтыг бууруулах арга хэмжээг тусган боловсруулж, ГЗБГЗЗГ-аар хянуулсан байна.</p> <p>Хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгавар батлагдсан байна.</p>	<p>Дархан хотын 2016-2035 оны Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Засгийн газрын 2020.09.09-ны №9 тогтоол, 3, 11, 12, 13, 24, 25, 29, 31 хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015.01.15-ны №08 тогтоолоор батлагдсан. Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажих барилгын зөвшилцөлийн зураг 7 хянаж баталгаажуулсан.</p> <p>2023 онд Залуус-1, Залуус-2 хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг ИТХ-н 2023.02.10-ны №08 тогтоол, 13-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тодотгож ИТХ-н 2023.09.28-ны №48 тогтоол гаргуулан, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгүй 4 хорооллын зургийн даалгавар боловсруулан ГЗБГЗЗГ-т хүргүүлэн хянуулсан.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>	



3.1. 9.4	Сумын төв, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан баримт бичгийн тоо	<b>Эхний хагас жилд:</b> “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д шинээр батлагдсан хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээллийг оруулсан байна.	Дархан-Уул аймгийн Хонгор, Орхон сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын ажлын зургийн даалгавар боловсруулан ГЗБГЗЗГ-тай зөвшилцөн аймгийн Засаг даргаар 2023.04.03-ны өдөр батлуулж Хонгор, Орхон сумын ЗДТГ-т хүргүүлээд байна. Орхон сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 50,0 сая төгрөг, Хонгор сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 170,0 сая төгрөгийг 2023 онд төсөвт суулгуулсан. Сумдын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тендер зарлагдсан ч гүйцэтгэгч шалгараагүй. Сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулагдан батлагдсан тохиолдолд хот төлөвлөлтийн цахим системд оруулна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1. 9.5	Рашаан сувилал, аялал жуулчлал бүхий газруудын байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах зорилгоор ерөнхий төлөвлөгөө боловсруулах шаардлагатай газруудын судалгааг хийж, зургийн даалгаврын төслийг боловсруулан, батлуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	Хот байгуулалтын цахим мэдээллийн санд бүртгэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Байгалийн Рашаан сувилал бүхий газруудын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй болсон байна.	Дархан-Уул аймгийн хэмжээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын газрын улсын тооллого, судалгааг хийж гүйцэтгэсэн. Уг ажлын хүрээнд аялал жуулчлал бүхий газрын байршил хил заагийг тогтоож хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төслийг хянуулахаар холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1. 9.6	Орон нутгийн онцлог, түүх, уламжлал, соёлтой холбоотой түүхэн болон архитектурын соёлын дурсгалт барилга байгууламжийн судалгааг хийж тэдгээрийг авч үлдэх, хамгаалах, хотын тохижилтод хамруулах ажлыг зохион байгуулах	Цахим системд бүртгэгдсэн түүх, соёл, архитектурын дурсгалт барилга байгууламжийн тоо	Орон нутгийн түүх, соёлын болон архитектурын дурсгалт барилга байгууламжийн судалгааг хийж тэдгээрийг авч үлдэх, хамгаалах, бүртгэх ажлыг зохион байгуулсан байна.	Дархан-Уул аймгийн хэмжээнд 34 хөшөө дурсгалыг цахим системд оруулж, орон нутгийн онцлог, түүх соёлыг үл хөдлөх дурсгалын 30 газрыг цаасан байдлаар бүртгэлжүүлсэн байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>

3.1. 9.7	Хот, суурин газрын дахин төлөвлөлтийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай талбайн байршил, хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоох талаар судалгаа хийж, мэдээлэл цуглуулах ажлыг иргэд, олон нийтийн оролцоог ханган зохион байгуулж, судалгааны үр дүнг ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан төсөл хэрэгжүүлэх талбайн байршлын тоо	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу дахин төлөвлөлтийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай талбайн байршил, хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоох талаар судалгаа хийж, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж, судалгааны үр дүнг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Дархан сум 5 дугаар багийн 19 дүгээр хороолол 8.2 га, 6 дугаар баг Баяндаваа 27.54 га, 6 болон 7 дугаар баг гэр хороолол 116 га, 8 дугаар багийн Дэвшлийн хэсэг 17.27 га талбайд Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах тухай хүсэлтийг гаргасан. Дархан сум 5 дугаар багийн 19 дүгээр хорооллын 8.2 га, 6 дугаар багийн 20.55 га талбайд төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулалтад зориулсан судалгааг хийж гүйцэтгэсэн. Дархан сум 6 дугаар баг Баяндаваа 27.54 га, 6 болон 7 дугаар баг гэр хороолол 116 га, 8 дугаар багийн Дэвшлийн хэсэг 17.27 га талбайн хүн амын мэдээлэл, инженерийн шугам сүлжээний нөөц хүчин чадлын мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан ажиллаж байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1. 9.8	Оршуулгын газрын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, газрыг баталгаажуулах, “Хот байгуулалтын кадастрын цахим систем”-д оршуулгын газрын газар ашиглалт, тохижилтын зураг төсөл боловсруулах, цэцэрлэгжүүлэлт тохижилт хийх ажлыг зохион байгуулах	Цахим системд бүртгүүлсэн оршуулгын газрын тоо, цэцэрлэгжүүлэлт тохижилт хийх төлөвлөгөө хийгдсэн газрын тоо, талбайн хэмжээ	Оршуулгын газруудыг “Хот байгуулалтын кадастрын цахим систем”-д бүртгэн, тохижилтын зураг төсөл боловсруулж, цэцэрлэгжүүлэлт тохижилт хийх ажлын төсвийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, тохижилтын ажлыг эхлүүлсэн байна.	Хот байгуулалтын кадастрын системд бүртгэгдсэн байдал: - Дархан сум, 15-р баг 2 га - Дархан сум, 15-р баг 3 га - Дархан сум, 5-р баг 0,32 га - Дархан сум, 5-р баг 6,4 га - Орхон сум, 1-р баг 4,7 га - Хонгор сум, 1-р баг 80,7 га - Хонгор сум, 1-р баг 3,2 га - Шарын гол сум, Санжит баг 29 га - Шарын гол сум, Санжит баг 1,6 га - Дархан сумын 15-р баг 3 га газарт “Дархангүн буян” ХХК газар ашиглалт, тохижилтын ажил хийж байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1. 10	<b>Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний мэдээллийг “Урбан менежер систем”-д бүртгэх</b>			
			<b>Эхний хагас жилд:</b>	

3.1. 10.1	2023 онд шинээр барих барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн мэдээллийг “Урбан менежер систем”-д бүртгэх	Системд бүртгэсэн мэдээллийн тоо	Шинээр нэмэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн мэдээллийг бүртгэсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Шинээр нэмэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийг мэдээллийг бүртгэсэн байна.	2023 оны бүтэн жилд шинээр ашиглалтанд орсон барилга 16, үерийн далан суваг 3, инженерийн шугам сүлжээ 16, авто зам 9 байгууламж, тохижилт, ногоон байгууламж инженерийн дэд бүтцийн мэдээллийг цахим системд бүртгэлжүүлсэн. Архитектур төлөвлөлтийн даалгавар 83, ажил эхлүүлэх зөвшөөрөл 24 цахимаар гарсан байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
3.1. 10.2	Аймгийн төвийн сумын гэр хорооллын бүсийн мэдээллийг цахим системд бүртгэх	Системд бүртгэсэн мэдээллийн тоо	<b>Эхний хагас жилд:</b> Гэр хорооллын бүсийн мэдээллийг бүрдүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Гэр хорооллын бүсийн мэдээллийг цахим системд бүртгэсэн байна.	Urban цахим системийн хөгжүүлэлт дуусаагүй тул Дархан сумын гэр хороолол, амины орон сууцны барилгуудыг ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн маягтын дагуу 354 цаасан хэлбэрээр мэдээллийг бүрдүүлсэн. Цахим систем ажиллахад мэдээллийг оруулахад бэлэн болно. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>

#### ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин/ биелэлт	Үнэл-гээ
4.1.1	<b>Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах</b>				
4.1.1.1	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна.	Дархан-Уул аймгийн Засаг даргын 2023.03.22-ны өдрийн 01-А/65 дугаар захирамжаар Дэс түшмэл Дөтгөөр зэрэг 2 албан хаагч, Ахлах түшмэл Дөтгөөр зэрэг 1 албан хаагч, Дэс түшмэл Тэргүүн зэрэг 1 албан хаагч, Дэс түшмэл Гутгаар зэрэг 1 албан хаагч, нийт 5 албан хаагчид үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн албан тушаалын зэрэг дэв ахиулан олгосон. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	

<p>4.1.1.3</p>	<p>Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах</p>	<p>Сул болон эзгүй орон тоо</p>	<p>- Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна</p> <p>- Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч, Орхон сумын газрын даамал, Хонгор сумын газрын даамал нийт 5 сул орон тоонд тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо авч Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 05, 101, 104, 129, 142 дугаар тогтоолоор нэр дэвшигдсэн албан хаагчдын ХАСУМ-ыг Авлигатай тэмцэх газраар хугацаанд нь хянуулж, газрын даргын тушаалаар томилсон.</p> <p>2023 оны 5-р сард газрын даргын Б/08 тушаалаар Орхон сумын Газрын даамлын өөрийн хүсэлтээр Зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд шилжүүлэн ажиллуулж байна. 2023 оны 11-р сард Газар, геодези, зураг зүйн улсын байцаагчийн сул орон тоонд шилжүүлэн ажиллуулах зарын дагуу 1 хүсэлт ирсэн, одоогоор ажил хүлээлцэх, орлох асуудалтай холбоотойгоор томилгоо хийгдээгүй байна.</p> <p>Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог 2023 оны 7 сараас хойш шилжүүлэн ажиллуулах 3, тусгай шалгалтын 4, нийт 6 удаа зарлуулсан боловч албан тушаалын тодорхойлолтод заагдсан тусгай шаардлагыг хангасан геодезийн мэргэжилтэй иргэн бүртгүүлээгүй байна.</p> <p>2023 оны 5-р сард газрын даргын Б/09 тушаалаар Суурь судалгаа мониторингийн мэргэжилтний, 2023 оны 10-р сард Б/18 тушаалаар Газрын төлбөр, татвар, үнэлгээ хариуцсан мэргэжилтний түр эзгүй /хүүхэд асрах чөлөөтэй/ орон тоонд Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс томилсон.</p> <p>Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний түр эзгүй албан тушаалын чиг үүргийг Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтнээр хавсран гүйцэтгүүлэхээр Авлигатай тэмцэх газраар /2023.05.31-ний 05/9664 тоот/ ХАСУМ-ийг хянуулж, газрын даргын 2023 оны Б/11 тушаалаар хавсран гүйцэтгэхээр зохицуулсан.</p> <p>Архивын ажилтны орон тоог 3 удаа, албан хэрэг хөтлөлтийн ажилтны сул орон тоог 2 удаа, нягтлан</p>
----------------	---	---------------------------------	--	---

				<p>бодогчийн сул орон тоог 1 удаа байгууллагын фэйж хуудас, фэйсбүүк хуудаст нээлттэй зарласны дагуу ирүүлсэн бичиг баримтын сонгон шалгаруулалт болон ярилцлага зохион байгуулан албан хаагчдыг сонгон шалгаруулж ажилд авсан.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
4.1.1.5	<p>“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах</p>	<p>Төлөвлөсөн арга хэмжээний тоо</p>	<p>“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>ГХБХБГ-ын даргаар Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2023 оны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1-р улиралд батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хамт ГЗБГЗЗГ-т 2023.12.18-ны өдрийн дотор хүргүүлнэ. Төлөвлөгөөний дагуу:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дотоод журамд заасан үндэслэлээр 9 албан хаагчид 0-16 хүртэл насны хүүхдийн төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгосон. Эмчийн магадлагаатай 5 албан хаагчид цалинтай чөлөө олгосон.</li> <li>- Нийт албан хаагчдад хоол, унааны мөнгийг тухай бүрт олгож байна. 2023 оны 11-р сараас газрын даргын А/41 дүгээр тушаалаар унаа хооны 5000 төгрөгийг 10000 төгрөг болгож нэмэгдүүллээ.</li> <li>- 2 албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж олгосон.</li> <li>- 4 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлэн аймгийн Засаг даргын захирамж гаргуулсан.</li> <li>- Газрын даргын 2023.06.05-ны өдрийн А/17 дугаар тушаалаар нийт 5 албан тушаал, 3 төрийн үйлчилгээний албан хаагчийн цалинг Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолыг үндэслэн нэмэгдүүллэн.</li> <li>- Албан хаагчдад үндсэн цалингаас гадна зэрэг дэвийн нэмэгдэл, төрийн албанд ажилласан жилийн нэмэгдэл, хавсран гүйцэтгэсний нэмэгдэл /2 албан хаагчид/, орон нутгийн нэмэгдэл улсын төсвөөс 20 хувь /ТЗ нарт 1-р сараас, ТҮ нарт 7-р сараас/, орон нутгийн төсвөөс 40 хувиар /ТЗ нарт 7-р сараас/ тус тус олгож байна. Төсвийн хэмнэлтээс үүдэн ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 11-12-р сард орон нутагт ажилласны нэмэгдлийг ТЗ нарт 20 хувиар нэмэгдүүлэн олгох асуудлыг албан хаагчдын хурлаар хэлэлцүүлж, 100 хувийн саналаар дэмжигдсэн тул газрын даргын А/42 тушаалаар орон нутагт ажилласны</li> </ul>

				<p>нэмэгдлийг ТЗ-ны албан хаагч нарт 40 хувиар олгож байна.</p> <p>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн урамшууллыг холбогдох шийдвэрийн дагуу 2, 3, 4-р улиралд тус бүр 40 хувиар олгосон байна.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
4.1.1.6	Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтийг хангах	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	<p>- Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажилласан байна.</p> <p>- Албан хаагчдын 2022 оны ээлжийн амралтын хуваарийг шинэчлэн Газрын даргаар батлуулсан байна.</p> <p>- Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган ГЗБГЗЗГ-т тайлагнасан байна.</p>	<p>- 2023 онд ажилд шинээр орсон 6 албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын бүтэц бүрэлдэхүүнээ танилцуулсан.</p> <p>- Энэ онд төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоонд 5 иргэнийг ТАСЗ-ын тогтоолын дагуу, 2 иргэнийг шилжин ажиллах хүсэлтийн дагуу, түр эзгүй орон тоонд 2 иргэнийг Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэнээс тус тус ажиллуулж байна /ХДЖ 4.1.1/. Төрийн үйлчилгээний 3 албан тушаалыг нээлттэй зарлан бичиг баримт, ярилцлагын сонгон шалгаруулалт зохион байгуулж ажилд авсан.</p> <p>- Нийт албан хаагчдын ажлын цагийн ирцийн мэдээг сар бүр /6 удаагийн/ гаргаж, бүртгэлийн мэдээнд үндэслэн цалинг тооцон олгож байна /ХДЖ 6.1.2/.</p> <p>- Байгууллагын албан хаагчдын цалин хөлсний хэмжээг газрын даргын 2023 оны А/01 дүгээр тушаалаар батлан, сар бүрийн 10, 25-нд олгож байна /ХДЖ 7.1.1, 7.1.2/.</p> <p>- 1 улиралд 13 албан хаагчдыг эмнэлгийн бүрэн үзлэг, оношлогоонд үнэ төлбөргүй хамруулсан /ХДЖ 7.5.7/.</p> <p>- Байгууллагын албан хаагчдын 16 хүртэлх насны нийт 31 хүүхдүүдэд Хүүхдийн баяр, Шинэ жилийн баярыг тохиолдуулан бэлэг өгсөн /ХДЖ 7.5.4/</p> <p>- Албан хаагчдын 2022 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн 4 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлэхээр аймгийн Засаг даргад хүсэлт өгч, захирамж гаргуулсан /ХДЖ 7.2.1.3/.</p> <p>- 11 албан хаагчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу цалинтай чөлөө олгосон /ХДЖ 6.2.3/.</p> <p>- Газрын даргын А/04 тушаалаар байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 5 ахмадад Цагаан сарын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлсэн /ХДЖ 7.5.1/.</p>

				<ul style="list-style-type: none"> <li>- Өндөр насны тэтгэвэртээ гарсан 2 албан хаагчид хүндэтгэл үзүүлэн газрын даргын А/34 дугаар тушаалаар үнэ бүхий зүйл дурсгасан /ХДЖ 7.5.1/.</li> <li>- Энэ онд нийт 46 өдөр, 24 албан хаагчдыг /давхардсан тоогоор/ томилолтоор бусад аймаг, нийслэлд ажиллуулсан байна /ХДЖ 8.1, 8.2, 8.3/</li> <li>- Газрын даргын 2023.03.01-ний өдрийн А/05 дугаар тушаалаар Ээлжийн амралтын хуваарь батлаж, 20 албан хаагчаас 16 албан хаагч ээлжийн амралтаа авсан, 4 албан хаагчийн ээлжийн амралт авах дотоод журамд заасан томилогдсоноос хойш 6 сарын хугацаа болоогүй /ХДЖ 6.1.4/.</li> </ul> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
4.1.1.7	Салбарын хэмжээнд “Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ГЗБГЗЗГ-т тайлагнасан байна.	<p>ГХБХБГ-ын даргаар Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр салбарын хэмжээнд зохион байгуулах ажлын 2023 оны төлөвлөгөөг 1-р улиралд батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ГЗБГЗЗГ-т 2023.12.18-ны өдрийн дотор хүргүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- ГХБХБГ-ын бүтэц орон тоогоор 26, үүнээс ажиллаж буй эмэгтэй албан хаагчдын тоо 15, эрэгтэй албан хаагч 6, хүүхэд асрах чөлөөнд байгаа 2, нийтдээ 21 албан хаагчийн хүний нөөцтэй. Манай байгууллагын хүйсийн харьцаа 30:70, эрэгтэй 6, эмэгтэй 15 байна. Боловсролын байдлаар Магистр-7 /30.4%/ Бакалавр-15 /65.2%/, Диплом-1 /4.4%/ ажилладаг.</li> </ul> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100</i></p>
4.1.1.8	Салбарын хэмжээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах” ажлыг зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээрх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг гарган ГЗБГЗЗГ-т тайлагнасан байна.	<ul style="list-style-type: none"> <li>➢ Иргэний барилгын төлөвлөлтөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин бүрдүүлэх стандартыг баримтлан дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд шинээр баригдаж буй болон ашиглалтанд ороогүй удаагүй барилга байгууламжид үзлэг, хяналт хийх ажлын хэсэг 2023.05.23-нд ажилласан. Ажлын хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл н.Батсүх, ХХҮГ-ын холбогдох мэргэжилтэн н.Батцэцэгийн хамт оролцов. Үзлэгээр: <ul style="list-style-type: none"> <li>- Хүслэн төв</li> <li>- Спортын ордон</li> <li>- S market 24- Газар өгөөж ХХК</li> </ul> </li> </ul>

				<ul style="list-style-type: none"> <li>- Цээнэ эмнэлэг</li> <li>- Авто тээврийн үндэсний төв зэрэг барилгуудыг үзэж хяналт хийсэн.</li> <li>➤ Шинээр зураг төсөл хийхээр төлөвлөсөн 83 архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан 24 эх загвар зурагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц, ариун цэврийн байгууламжийг зураг төсөлд тусгах талаар даалгаварт тусгасан.</li> <li>➤ ГХБХБГ-ын даргаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулах ажлын 2023 оны төлөвлөгөөг 1-р улиралд батлуулсан. 8 арга хэмжээ төлөвлөснөөс 7 арга хэмжээ хэрэгжиж, 1 арга хэмжээ санхүүгийн шалтгааны улмаас тасалдсан байна.</li> </ul> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
4.1.1.9	Байгууллагын ахмад настныг бүртгэлд авах, тэдэнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын ахмад настныг бүртгэлд авах, тэдэнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх арга хэмжээг 2023 оны 2 болон 10 дугаар сард зохион байгуулсан байна.</li> <li>- Шагналд тодорхойлох, тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлүүлсэн байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын ахмад настнуудыг 2023 оны 2-р сард бүртгэлжүүлж, 2023 оны ГХБХБГ-аарын даргын А/04 тушаалаар цагаан сарын баярын 490.0мян төгрөгийн тусламжийг 5 ахмадад үзүүлсэн.</li> <li>- 2023 онд өндөр насны тэтгэвэртээ гарсан 2 албан хаагчид газрын даргын А/34 тушаалаар үнэ бүхий зүйл дурсгаж, хүндэтгэл үзүүлсэн.</li> <li>- 10-р сараас өндөр насны тэтгэвэртээ гарсан 7 албан хаагч, одоо ажиллаж буй 3 албан хаагчийг төрийн өндөр дээд шагналд нэр дэвшүүлэхээр ажил байдлын тодорхойлолт, анкетыг бэлтгэж, 12 сарын 14-нд ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Өндөр насны тэтгэвэртээ гарсан 1 албан хаагчид 2023.12.08-нд Найрамдлын дархан тэмдэгээр шагнасан.</li> </ul> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
4.1.1.1 2	Албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу шинэчлэн бүрдүүлэх	Албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу шинэчлэн бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд 2023 онд нийт 26 албан хаагчийн мэдээллийг тулгалт хийж шинэчлэн, холбогдох тушаал шийдвэрийг хавсарган хөтөлсөн. Цаасан суурьтай одоо ажиллаж буй 20 албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу баяжилт хийсэн.</li> </ul> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>



4.1.1.1 3	Салбарын албан хаагчдын асуудлыг байгуулах шагналын зохион	Шагнагдсан албан хаагчийн тоо	Албан хаагчдын ажлын үр дүнг үндэслэн төрийн дээд шагнал, яам, агентлагийн шагнал, салбарын болоод бусад байгууллагын шагналд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	2023 оны 1-р сард 2 албан хаагчийг төрийн дээд одон медальд тодорхойлон, Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн боловч шагнал ирээгүй. 12-р сард салбарын шагналд нийт 8 албан хаагч, аймаг орон нутгийн 4 шагнал, төрийн 3 шагналд 10 албан хаагч нийт 25 албан хаагчийг нэр дэвшүүлсэнээс Салбарын Тэргүүнээр 3 албан хаагч, Яамны жуух бичгээр 1 мэргэжлийн байгууллагын ажилтан, Агентлагын жуух бичгээр 3 албан хаагч, Найрамдлын Дархан тэмдэгээр 2 албан хаагч, 1 тэтгэвэрт гарсан албан хаагч, 1 мэргэжлийн байгууллагын ажилтан, Аймгийн Тэргүүний ажилтнаар 1 албан хаагч, Аймгийн Засаг даргын жуух бичгээр 3 албан хаагч, 1 мэргэжлийн байгууллагын ажилтан, “Дархан 60 жил” тэмдэгээр 2 тэтгэвэрт гарсан албан хаагчдыг тус тус шагнаж урамшуулсан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
4.1.2	<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах</b>	12 удаа	<b>Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг заасан хугацаанд оруулсан байна.</b>	
4.1.2.1	Байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг Шилэн	Мэдээллийн тоо	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр оруулж баталгаажуулсан байна.	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр буюу 12 сарын 10-ны байдлаар 11 удаа <a href="http://dar.mof.gov.mn">dar.mof.gov.mn</a> системд хугацаанд нь мэдээлсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>

	дансны цахим хуудсанд оруулж баталгаажуулах				
4.1.3	<b>Авлигын тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах</b>	<b>1 төлөвлөгөө,  3 тайлан,</b>	<b>Төлөвлөө болон тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.</b>		
4.1.3.1	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах	Тайлангийн тоо	Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан байна  Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБГЗЗГ-т хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна.	Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргаар батлуулсаны дагуу, хагас жилийн хэрэгжилтийг 2023 оны 06 сарын 13-ны өдрийн 386 тоот бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. 16 арга хэмжээ төлөвлөснөөс 15 арга хэмжээ хэрэгжсэн, 1 арга хэмжээ санхүүжилтгүйн улмаас хэрэгжээгүй байна. Бүтэн жилийн хэрэгжилтийг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хамтаар ГЗБГЗЗГ-т 2023.12.18-ны өдрийн дотор хүргүүлнэ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
4.1.3.2	Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагааг зохион байгуулах	Мэдүүлэг гаргагчийн тоо	Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө авах ажлыг зохион байгуулсан байна.	2023 оны 2-р сард ХАСХОМ-ийг 5 албан хаагч гаргаж, хугацаанд нь тайлагнасан. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>	
4.1.3.3	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх	Мэдүүлгийн тоо	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх	Газрын эрх зүйн харилцааг шийдвэрлэх хуралд оролцох албан хаагчдаас 10 удаагийн 45 /давхардсан тоогоор/ ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг хүлээн авч бүртгэсэн байна. Үүнээс зөрчил үүссэн мэдэгдэл байхгүй.	

			арга хэмжээг зохион байгуулсан байна.	Хэрэгжилтийн хувь: 100%
4.1.3.4	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх ажлыг зохион байгуулах	Мэдүүлгийн тоо	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.	Төрийн жинхэнэ албанд шинээр томилогдох 5 албан хаагчийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газраар хугацаанд нь хянуулж, дүгнэлт гаргуулсан. Үүнд: Авлигатай тэмцэх газрын 2023.03.23-ны 05/4811 тоот бичгээр Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний ХАСУМ, 2023.05.31-ний 05/9664 тоот бичгээр Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний ХАСУМ, 2023.11.21-ний 05/18895 тоотойр Газар, геодези, зураг зүйн улсын байцаагч, Өргөх байгууламжийн улсын байцаагч, Барилга, хот байгуулалтын хэлтсийн даргын ХАСУМ-ыг тус тус хянуулсан тухай хариу ирж, зөрчилгүй дүгнэлт авсан. Хэрэгжилтийн хувь: 100%
4.1.4	<b>Тогтоол шийдвэрийн, биелэлтэд хяналт тавих</b>	<b>Тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлсөн байдал</b>	<b>Бүртгэлд авсан тогтоол шийдвэрийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд холбогдох газарт тайлагнасан байна.</b>	
4.1.4.1	Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗГ болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах	Тогтоол, шийдвэрийн тоо	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэлжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох газарт тайлагнасан байна.	Барилга, хот байгуулалтын яамнаас 1, ГЗБГЗЗГ-аас 1 тогтоол, шийдвэрийг хүлээн авч, цахим системд бүртгэсэн байна. Аймгийн Засаг даргын 95 захирамж, Дархан сумын Засаг даргын 36 захирамж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 4 тогтоолыг тус тус бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьсан. Хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газарт 2023 оны 12 сарын 25-ны дотор хүргүүлдэг. Хэрэгжилт 100 хувьтай. Хэрэгжилтийн хувь: 100%
4.1.5	<b>Байгууллагын хэмжээнд эрх зүйн баримт бичиг боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тави</b>			
4.1.5.1	Газрын даргын тушаалын үндэслэлийг хянаж, бүртгэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Тушаалын төслийн тоо	Газрын даргын тушаалын төслийг боловсруулж, бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг гаргасан байна.	12 сарын 10-ны өдрийн байдлаар 68 газрын даргын тушаалын төслийг боловсруулж, баталсан. Тогтоол шийдвэрийн бүртгэлийн дэвтэрт бүртгэж, хэрэгжилтийг харгалзах хэсэгт тэмдэглэдэг, хэрэгжилт 100 хувьтай. Хэрэгжилтийн хувь: 100%
4.1.6	<b>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх ажлыг зохион байгуулах</b>			

4.1.6.1	Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж, тайлагнах	3 төлөвлөгөө,  6 тайлан	<p>-Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, ГЗБГЗЗГ-ын дарга болон аймгийн Засаг даргаар тус тус хянуулан, баталсан байна.</p> <p>-Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p> <p>-Нэгжүүдийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг тайлагнасан байна.</p>	<p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ГЗБГЗЗГ-ын даргаар 2023 оны 2-р сард хянуулан, батлуулсан. Мөн Нэгжийн төлөвлөгөөг байгууллагын төлөвлөгөөний дагуу боловсруулж, газрын даргаар хянуулан батлуулсан. Хэрэгжилтийг хагас жилийн хэрэгжилтийг 2023.06.14-ний өдрийн 393 дугаар бичгээр ГЗБГЗЗГ болон аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>Нэгжүүдийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 12 сарын 11-нд хураан авч, ХШҮ-ний багаар хэлэлцүүлсэн байна, хэрэгжилт ГУХэлтсийн төлөвлөгөө 90 хувьтай /тасалдсан ажил Мониторинг, Геодезийн чиглэлээр/, БХБХэлтсийн төлөвлөгөө 95 хувийн /тасалдсан ажил Барилгын материал үйлдвэрлэл, Urban мэдээллийн систем чиглэлээр/ хэрэгжилттэй байна.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
4.1.6.2	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах	Нийт албан хаагчдын төлөвлөгөө, тайлан	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах ажлыг зохион байгуулж, биелэлтийг үнэлж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	<p>2023 оны 1-р улиралд 16 албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан. 2, 3, 4-р улиралд албан хаагчдаас гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хурааж, ХШҮ-ний багаар үнэлүүлсэн. Үнэлгээний дагуу 2, 3 дугаар улиралд давхардсан тоогоор 33 албан хаагчид үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 20-40 хувиар олгосон байна.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
<b>4.1.7</b>	<b>Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах</b>			

4.1.7.1	Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан сумдын тоо	Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	2023 оны 11 сард Орхон, Шарын гол, Хонгор сумдын газрын даамлуудыг ГХБХБГ-т ирүүлж, кадастрын мэдээллийн системд ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэсэн байдал, нэгж талбарын хувийн хэргийн бүрдэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, төлөвлөлтийн дагуух газар олголт, нэгж талбарын өөрчлөлт, хаягжуулалтын үйл ажиллагаанд ГЗБГЗЗГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний багийн зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлуудыг шалган, цаашид мөрдөх чиглэл зөвлөмжийг өгсөн. 2023 оны 2-р сард байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг, бичмэл тайлангийн хамтаар 2, 3, 4-р улиралд авч, ХШҮ-ний багаар үнэлүүлсэн. 4 сумын даамал хангалттай үнэлүүлсэн байна. Шаардлагатай мэргэжил арга зүйн зөвлөгөөг холбогдох мэргэжилтнүүдээс тухай бүрт өгч ажиллажээ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
4.1.7.2	Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдалтын хувь	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	Дархан-Уул аймагт геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж байгаа “Гео од”, “Ёлт сүрвэй”, “Эхлэх цэг хангай” ХХК-уудын үйл ажиллагаанд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг доорхи чиглэлээр хийж гүйцэтгэсэн. ❖ Суурь нөхцөл шаардлага хангаж буй эсэх. ❖ Багаж, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа ❖ Хүний нөөцийн мэдээлэл Хянан баталгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Эхлэх цэг хангай ХХК, Гранд амур ХХК-уудад ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн чиглэлүүдийг хүргүүлж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
<b>4.1.8 Хурал, зөвлөгөөн зохион байгуулах</b>				
4.1.8.1	Салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, “Газрын харилцааны ажилтны өдөр”-т оролцох	2 арга хэмжээ	<b>Эхний хагас жилд:</b> Салбарын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-нд оролцсон байна. Байгууллагын албан хаагчдыг зөвлөгөөнд цахимаар оролцуулсан байна.	2023 оны 2-р сард Удирдах ажилтны зөвлөгөөнд байгууллагын дарга оролцсон. Байгууллагын албан хаагчдын зөвлөгөөнд цахимаар албан хаагчдыг хамруулсан. Газрын харилцааны ажилтны өдрийн хүрээнд волейбол эмэгтэй багийн төрөлд 1 албан хаагч бүсийн багт тоглож

			Газрын харилцааны ажилтны өдрийг хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд албан хаагчдыг оролцуулсан байна.	алтан медаль авсан бол волейбол эрэгтэй багийн төрөлд 3 албан хаагч тоглосон. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
<b>4.1.9</b>	<b>Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах</b>			
4.1.9.1	Батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Сургалтын тоо	“Салбарын хэмжээнд байгууллагаас хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө”-г боловсруулан Газрын даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр ГЗБГЗЗГ-т тайлагнасан байна.	Байгууллагын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг байгууллагын даргаар 1-р улиралд батлуулсаны дагуу хэрэгжилтийг 2023 оны 06 сарын 13-ны өдрийн 386 тоот бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Бүтэн жилийн хэрэгжилтийг ГЗБГЗЗГ-т 12 сарын 18-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэж байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
<b>4.1.11</b>	<b>Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх</b>			
4.1.11.1	Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Салбарын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээг орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулж, нийтэд хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд: - Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээ - Газрын биржийн цахим системийн үйл ажиллагаа - Газрын цахим систем /egazar.gov.mn/-ээс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээ - Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	Байгууллагын цахим хуудсанд 26 ширхэг шинэ мэдээ, 56 удаагийн шинэчлэлт, өөрчлөлт хийсэн. Байгууллагын цахим хуудасны хандалтын тоо 2023 оны 11-р сарын 24-ний байдлаар сард дунджаар хэрэглэгчид 861 удаа зочилж, нийт 9481 удаа зочилсон байна. Зочилсон цагийн хувьд өдрийн цагаар буюу 9:00 цагаас 18:00 цагийн хооронд хамгийн их зочилж, газар эзэмших /678/, өмчлөх /824/ хүсэлтийн маягт, өргөдөл бичих загвар /240/-ыг хамгийн олон удаа татаж авсан байна. Байгууллагын фэйсбүүк хуудсанд 66 ширхэг шинэ мэдээ, БХБЯ, БХТ-ийн мэдээлэл 121, ГЗБГЗЗГ-ын мэдээлэл 104, Орон нутгийн ТВ-ын мэдээлэл 11, Дархан-Уул ЗДТГ-ын мэдээлэл 98, бусад төрийн байгууллагуудын мэдээлэл 71, нийт 428 мэдээлэл хуваалцаж түгээв. 2023 оны 11-р сарын 26-ны байдлаар Фэйсбүүк хуудасны хандалтын тоо 88390, хуудасны дагагчийн тоо 6005 болсон байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
<b>4.1.12</b>	<b>Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах</b>			
4.1.12.1	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл	Ирүүлсэн албан бичгийн тоо, Явуулсан албан бичгийн тоо,	Ирсэн, явсан, өргөдөл гомдлыг “Байгууллагын удирдлагын цогц цахим систем”-д бүртгэлжүүлж, тайлан мэдээг гаргасан байна.	- 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс 12 сарын 12-ны өдрийн хооронд абле программд нийт 1296 албан бичиг /хариутай 977/, 510 өргөдөл /хариутай 399/ ирсэнээс 964

	гомдлыг шийдвэрлэж, тайлагнах	Өргөдлийн тоо,  Тайлангийн тоо	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.</li> <li>- Байгууллагаас явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.</li> <li>- Хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна.</li> <li>- Өргөдөл, гомдлын мэдээг холбогдох байгууллагад улирал бүр тайлагнасан байна.</li> </ul>	<p>албан бичиг, 417 өргөдөл шийдвэрлэн, 225 албан бичиг, 93 өргөдөл хяналтанд бүртгэжээ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- ГХБХБГ-аас 2023 оны 1 сарын 01-ний өдрөөс 12 сарын 12-ны өдрийн хооронд нийт 757 албан бичиг явуулж, 68 даргын тушаал батлагдсан байна.</li> <li>- Өргөдөл гомдлын 1, 2, 3-р улирлын мэдээг Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст тухай бүрт албан тоотоор хүргүүлсэн. Өргөдөл гомдлын 4-р улирлын мэдээг 2023.12.25-нд явуулна.</li> </ul> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
<b>4.1.13</b>	<b>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах</b>			
4.1.13.1	Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах	Хадгаламжийн нэгжийн тоо	<p>2023 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх хуваарь гарган батлуулсан байна.</p> <p>2022 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” болон нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивласан байна.</p>	<p>2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг нөхөн бүрдүүлэх хуваарийн хамт 2023 оны 2-р сард газрын даргаар батлуулсан.</p> <p>2022 оны хөтөлж дууссан 31 баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивласан.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
4.1.13.2	Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын архивын чиг үүргийг хэрэгжүүлэх	1 төлөвлөгөө	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <p>Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангасан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b></p> <p>Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлсэн байна.</p>	<p>Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг 9-р сард газрын даргаар батлуулж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу архивын <a href="mailto:archive2@gazar.gov.mn">archive2@gazar.gov.mn</a> цахим системд 300 орчим хадгаламжийн нэгжийг бүртгэж, 700 орчим нэгж талбарын нөхөн бүрдүүлэлт хийсэн, байнга хадгалах 700 хадгаламжийн нэгжийн бүртгэлийн дагуу тооллого явуулж, хуудас дугаарлаагүй баримтыг дугаарлаж ажиллаж байна. Хадгаламжийн сангийн ариун цэврийг хангах ажлын хүрээнд 2 болон 3 дугаар улиралд 100 хувь баримтын тоос шороог арчиж цэвэрлэсэн.</p> <p><i>Хэрэгжилтийн хувь: 100%</i></p>
<b>4.2.1</b>	<b>Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх</b>			

4.2.1.1	Төсвийн зардлыг бууруулж, хэмнэлт гаргаж ажиллах, бараа материалын болон үйлчилгээний орлогод хяналт тавьж орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх	Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна. Орлогын төлөвлөгөөг биелүүлж санхүү төсвийн зөрчилгүй ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан бөгөөд 12-р сарын 11-ний өдрийн байдлаар зөрчил, доголдолгүй байна. 2023 онд орлогын төлөвлөгөө өгөөгүй болно.  <i>Хэрэгжилтийн хувь: 100</i>
4.2.1.2	Байгууллагын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж, аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх	Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	2023 оны хагас жилийн байдлаар санхүүгийн тайланг олон улсын стандарт нийцүүлэн гаргаж Төрийн аудитаар хянуулан албан бичгээр өөрчлөлтгүй санал дүгнэлт авсан. Бүтэн жилийн санхүүгийн тайланг 2024 оны 1-р сард Төрийн аудитаар хянуулна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
4.2.1.3	Өр авлагыг цаг тухайд нь барагдуулж, өмнөх оныхоос бууруулж ажиллах	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх	Үүссэн өр, авлагыг цаг тухайд нь барагдуулж тайлант жилд өр, авлагыг бууруулан ажилласан байна.	2023 оны тайлант жилд өр, авлагагүй ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар үүссэн өр, авлагыг цаг тухайд нь барагдуулж ажиллаж байна. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
4.2.1.4	Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх	Үндсэн хөрөнгийн болон бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажилласан байна.	Үндсэн хөрөнгийн болон бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж албан хаагч нартай эд хөрөнгийн ашиглалтын хариуцлагын гэрээ байгуулж 2023 оны 6 сард бараа материалын тооллогын ажлыг зохион байгуулсан, зөрчилгүй. ГХБХБГ-ын даргын 12 сарын 11-ны А/44 тушаалаар үндсэн хөрөнгө болон бараа материалын жилийн эцсийн байдлаар тооллого хийж эхэлсэн, тайланг 12 сарын 15-ны өдрийн дотор Өмч хамгаалах байнгын зөвлөлд тайлагнана. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>
4.2.1.5	Санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайлан, Шилэн дансанд оруулах мэдээллийг хууль журамд заасан хугацаанд оруулж мэдээ тайланг холбогдох	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх	Хуульд заасан хугацаанд мэдээ тайланг тайлагнаж ажилласан байна. Мэдээ тайлангийн хугацааг хоцроохгүй байх.	2023 онд хуульд заасан хугацаанд мэдээ тайланг тайлагнаж ажилласан бөгөөд хугацаа хоцроосон мэдээ тайлан байхгүй. 12-р сарын Төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 2-ны өдрийн дотор ГЗБГЗЗГазарт хүргүүлнэ, мөн НДШ-ийн тайлан, татварын тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор цахимаар хүргүүлнэ. <i>Хэрэгжилтийн хувь: 100%</i>



	газруудад байна.	хүргүүлсэн				
--	---------------------	------------	--	--	--	--

ТАЙЛАН ХЯНАСАН:

Г.НЯМДОРЖ /ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА/

С.УНДРАХ /БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА/

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Ц.ЦЭНД-АЮУШ /ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН/